



ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК

2001
ЖИЛИЙН ТАЙЛАН



2001 оны Монгол Улсын шилдэг банк
“The Banker” - сэтгүүлээс...

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	2001	2000
Үзүүлэлт	сая. төгрөг	сая. төгрөг
Нийт орлого	16,415.5	16,101.9
Нийт зардал	7,157.3	4,930.5
Татварын өмнөх ашиг	9,258.2	11,171.4
Татвар	4,359.4	4,573.9
Цэвэр ашиг	4,898.8	6,597.5


	2001	2000
Тайлан тэнцэл	сая. төгрөг	сая. төгрөг
Нийт актив	111,782.1	97,409.9
Зээл /цэвэр/	33,347.8	21,005.2
Татан төвлөрүүлсэн хөрөнгө	94,164.4	77,980.6
Эрсдлээр жигнэгдсэн актив	124,474.7	98,585.3

Үзүүлэлтүүд	2001	2000
Өөрийн хөрөнгийн өгөөж	68.5%	111.4%
Активын өгөөж	4.4%	6.8%
Нийт зардал/орлогын харьцаа	43.6 %	30.6 %


Шалгуур үзүүлэлтүүд	2001.12.31	2000.12.31
1. 1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээ $\geq 5\%$	12.7%	27.7 %
2. Өөрийн хөрөнгийн хүрэлцээ $\geq 10\%$	15.7%	35.9 %
3. Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар $\geq 18\%$	62.4%	77.4 %
4. Гадаад валютын эрсдэл $< +40\%$	31.4%	16.3 %
5. Нэг зээлдэгчид олгосон зээл / өөрийн хөрөнгө $< 20\%$	20.7%	16.0 %
6. Өөрийн ажилтанд олгосон зээл / өөрийн хөрөнгө $< 5\%$	0.5%	0.2 %

	2001	2000
Нийт ажилтнууд	363	323
Үүнээс:		
Төв	239	211
Салбарууд	124	112


НИЙТ ОРЛОГО




НИЙТ АКТИВ



ЗЭЭЛ



ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГӨ



ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНКНЫ ТОВЧ ТҮҮХ

Монгол Улсын Засгийн газрын 1990 оны 71-р тогтоолыг үндэслэн Улсын Банкны Ерөнхий Хороо /хуучин нэрээр/-ны даргын баталсан 1991 оны 3/19 тоот тушаалын дагуу Худалдаа хөгжлийн банк байгуулагдаж 1991 оноос арилжааны банкны статустайгаар үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн бөгөөд одоогийн байдлаар тус банкны нийт дүрмийн сангийн 76 хувийг Монгол улсын Засгийн газар, 24 хувийг тус банкны ажиллагсад болон бусад хувь нийлүүлэгчид эзэмшдэг.

1991 оноос 2001 оныг дуустал 11 жилийн хугацаанд тус банкны тэнцлийн нийт эргэлт 30.1 дахин нэмэгдэж 33.1 триллион төгрөгт, тэнцлийн нийт хэмжээ 11.4 дахин нэмэгдэж 111.8 тэрбум төгрөгт, харилцагчдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ 53.5 дахин өсч 94.2 тэрбум төгрөгт тус тус хүрсэн байна.

Тус банк нь улс орны эдийн засагт оруулж буй хувь нэмэр, төлбөрийн чадвар, хөрөнгийн хэмжээ, үйлчилгээний соёлын түвшин, үйл ажиллагааны цар хүрээ зэрэг бүхий л үзүүлэлтээр манай улсын банк санхүүгийн зах зээлд тэргүүлэгч байр суурьтай, хамгийн том арилжааны банк юм. 2001 оны эцсийн байдлаар манай улсын банкны системийн нийт активын 33.6 хувь, гадаад активын 67.0 хувь, харилцах, хадгаламжийн дансны үлдэгдлийн 42.4 хувь, цэвэр зээлийн 26.0 хувь нь тус банкинд ноогдож байна.

Банк 2001 оны эцсийн байдлаар Улаанбаатар хотод 3 салбар, 4 тооцооны төв, Дорнод, Сэлэнгэ, Дархан-Уул, Орхон, Дорноговь аймагт салбар банк, Дорноговь аймгийн Замын-Үүд, Сэлэнгэ аймгийн Мандал, Дархан-Уул аймгийн Дархан сумуудад тооцооны төв, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг суманд тооцооны касстай, төв банкнаас гадна нийт 8 салбар банк, 7 тооцооны төв, 1 тооцооны касстайгаар үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд нийт 363 ажиллагсад ажиллаж байна.

Тус банк Дэлхийн банк, ХБНГУ-ын Засгийн газраас Монгол улсын Засгийн газарт олгосон төслийн зээлийг харилцагчдад дамжуулан зээлдүүлэх үйл ажиллагаа эрхэлж байгаагийн зэрэгцээ БНХАУ, Өмнөд Солонгос болон Энэтхэг улсын Засгийн газраас Монгол улсын Засгийн газарт олгосон зээлийн төлбөр тооцоог нь гүйцэтгэж байна.

Худалдаа, хөгжлийн банк нь:

- 1997 онд “Хэрэглэгчийн найдвартай түнш” байгууллага
- 1999 онд “Найдвартай татвар төлөгч” байгууллага
- 1999 онд “Оны шилдэг аж ахуйн нэгж”
- 2000 онд “Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч тэргүүний байгууллага”
- 2001 онд Олон улсын нэр хүнд бүхий “The Banker” сэтгүүлээс тус банкийг “2001 оны Монгол улсын шилдэг банк”
- 2001 онд “VISA International” байгууллагаас “VISA” картыг богино хугацаанд амжилттай нэвтрүүлснийг үнэлж “New market development award” буюу “Шинэ зах зээлд нэвтрүүлэгч” шагнал
- 2001 онд Кёкүшюзан сангаас Монгол улсын эдийн засагт оруулсан хувь нэмрийг нь үнэлж “Монголын төлөө өргөмжлөл”
- 2001 онд “Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч найдвартай хамт олон”
- 2001 онд “Татвар төлөгч тэргүүний байгууллага”-аар тус тус шалгарсан.

Агуулга

- 6 Гүйцэтгэх захирлын илгээлт
- 8 Худалдаа, хөгжлийн банкны стратеги
- 10 Монгол улсын эдийн засгийн тойм
- 11 Банк, санхүүгийн систем
- 15 Худалдаа, хөгжлийн банкны тайлан тэнцэл
- 23 Бүтээгдэхүүн, үйлчилгээ
- 32 Салбар банкуудын үйл ажиллагаа
- 33 Боловсон хүчний бодлого, бүтэц зохион байгуулалт
- 36 Банкны хаяг, байршлууд
- 38 Хөндлөнгийн хяналтын тайлан

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ИЛГЭЭЛТ



Гүйцэтгэх захирал С. Мөнхбат

Эрхэмсэг ноёд, хатагтай нар аа,

Та бүхэнд Худалдаа хөгжлийн банкны 2001 оны үйл ажиллагааны тайланг толилуулахад таатай байна.

Өнгөрсөн 2001 он нь тус банкны хувьд төдийгүй нийт улс орны эдийн засагт ололт амжилтаар дүүрэн жил болон өнгөрлөө.

2001 онд хэдийгээр дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт харьцангуй бага байсан ч, улсын төсвийн алдагдал буурсан, төгрөгийн ам. доллартай харьцах ханш болон инфляци тогтворжсон, улсын валютын нөөц нэмэгдсэн зэрэг нааштай үзүүлэлтүүд эдийн засгийн макро түвшинд гарсан юм.

2001 онд хэд хэдэн хувийн болон гадаадын хөрөнгө оруулалттай арилжааны банк болон банк бус санхүүгийн байгууллагууд шинээр байгуулагдсан нь дотоодын банк, санхүүгийн зах зээлийн өрсөлдөөнийг урьд урьдынхаас улам нэмэгдүүлсэн юм. Гэсэн хэдий ч тайлант онд бид банкны үйл ажиллагааг

зах зээлийн өрсөлдөөнд зохицуулан эрсдэлийн удирдлагыг оновчтой зохион байгуулж, хөрөнгийн эрсдлийг бууруулан төлбөрийн чадвараа бэхжүүлж, зах зээлд эзлэх байр суурь, банкны нэр хүндээ улам бататгахад гол анхаарлаа чиглүүлж ажилласны үр дүнд санхүүгийн зах зээлд давамгайлах байр сууриа хадгалан үлдэж чадсан юм. Тайлант оны эцсийн байдлаар манай улсын банкны системийн нийт активын 33.6 хувь, гадаад активын 67.0 хувь, харилцагчдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн 42.4 хувь, цэвэр зээлийн 26.0 хувь нь тус банкинд ногдож байна.

эрсдэлийн удирдлагыг оновчтой зохион байгуулж, хөрөнгийн эрсдлийг бууруулан төлбөрийн чадвараа бэхжүүлж, зах зээлд эзлэх байр суурь, банкны нэр хүндээ улам бататгахад гол анхаарлаа чиглүүлж ажилласны үр дүнд санхүүгийн зах зээлд давамгайлах байр сууриа хадгалан үлдэж чадсан юм. Тайлант оны эцсийн байдлаар манай улсын банкны системийн нийт активын 33.6 хувь, гадаад активын 67.0 хувь, харилцагчдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн 42.4 хувь, цэвэр зээлийн 26.0 хувь нь тус банкинд ногдож байна.

Монгол улсын засгийн газраас 2001 оныг үндэсний үйлдвэрлэлийг дэмжих жил болгон зарласан явдал нь тус банкныг бодит эдийн засаг, ялангуяа үйлдвэрлэлийн салбарын үйл ажиллагааг санхүүжүүлэх, зээлээр дэмжихэд бодлогоо түлхүү хандуулахад нөлөөлсөн. Энэ бодлогын хүрээнд тус банк зээлийн хүүгээ бууруулах болон зээл олголтыг нэмэгдүүлэх гэсэн хоёр чиглэлт арга хэмжээг авч хэрэгжүүлсэн бөгөөд үүний үр дүнд зээл олголт өмнөх 2000 онтой харьцуулбал бараг 2 дахин өсч 86.6 тэрбум төгрөгт хүрсэн байна. Хэдийгээр өнгөрсөн онд гадаад зах зээл дээрх хадгаламжийн хүү ихээхэн хэмжээгээр буурсан ч тус банк зээл олголтын хэмжээг нэмэгдүүлснээр хүүгийн орлогыг өмнөх оныхоос нэмэгдүүлж чадсан юм. Нөгөө талаар зээлийн хүү өнгөрсөн онтой харьцуулбал төгрөгийн зээлийн хувьд 7.2 пунктээр, валютын зээлийн хувьд 1.2 пунктээр буурсан байна. Мөн түүнчлэн үйлдвэрлэлийг дэмжих, экспортыг урамшуулах төрийн бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд алт, зэс олборлодог компаниудад эрсдэлийн үнэлэмж тогтоосны үндсэн дээр ердийнхөөс бага хүүтэйгээр зээл олгох шинэ тогтолцоог бүрдүүлсэн юм.

Дээр дурьдсанчлан тус банк алт, зэс, жонш олборлолт, ноолуур, махны экспорт, гурилын үйлдвэрлэл, нефть импорт, эрчим хүч, тээвэр, холбооны зэрэг манай улсын эдийн засагт зонхилох нөлөө үзүүлдэг, төрийн бодлогоор дэмжигдэж байгаа салбаруудад үйл ажиллагаа явуулдаг, тус банктай тогтвортой харилцаа бүхий аж ахуйн нэгж, компаниудын үйл ажиллагааг зээлээр дэмжихэд түлхүү анхаарч ажиллалаа. Энэ онд дотоодын эх үүсвэрээр олгосон нийт зээлийн 62.9 хувийг үйлдвэрлэлийн салбарт олгожээ.

2001 онд тус банк опшин, своп, форвард зэрэг санхүүгийн деривативуудыг нэвтрүүлснээр харилцагч байгууллагууд болон бусад арилжааны банкууд тус банкаар дамжуулан олон улсын валютын зах дээр арилжаа хийх бололцоотой болсон, мөн аж ахуйн нэгжүүдээс алт худалдан авдаг болсон зэрэг нь цаашид энэ төрлийн үйлчилгээг өргөжүүлэх, банкны орлогыг нэмэгдүүлэх ажлын эхлэл байсан гэдгийг тэмдэглэе.

ХХБанк нь ХБНГУ-ын Засгийн газар болон Дэлхийн банкны Олон Улсын Хөгжлийн Ассоциацаас Монгол Улсын Засгийн газарт хувийн хэвшлийг дэмжих зориулалтаар олгож буй зээлийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэгч банкаар шалгаран ажиллаж ирсэн бөгөөд эдгээр хөтөлбөрүүдийн хүрээнд тайлант оны эцсийн байдлаар нийт 8 аж ахуйн нэгжид 4.7 сая дойч марк, 6 аж ахуйн нэгжид нийт 996.2 мянган ам.долларын дунд болон урт хугацааны зээл олгосон байна.

Тус банк 2001 онд зээлийн багцыг сайжруулах, чанаргүй зээлийг нөхөн төлүүлэх асуудалд онцгой анхаарал хандуулж, шат дараатай арга хэмжээ авч ажилласны үр дүнд чанаргүй зээлийн өрийн үлдэгдлийг өмнөх онтой харьцуулбал 12.3 хувиар, түүний дотор муу зээлийн өрийн үлдэгдлийг 39.0 хувиар бууруулсан байна.

Бид өнгөрсөн онд банкны дотоод зохион байгуулалт, бүтцэд зах зээлийн өөрчлөлт, банкны цаашдын хөгжлийн зорилтод нийцүүлэн зохих өөрчлөлтийг оруулж эхэлсний зэрэгцээ, алт, валютын арилжаа, зээлийн үйл ажиллагааг зохицуулах заавар, журмуудыг шинэчлэн боловсруулж үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тус банкны 2001 оны санхүүгийн тайлан тэнцэлд олон улсын нэр хүнд бүхий “Эрнст энд Янг” компани хөндлөнгийн хяналт хийж гүйцэтгэлээ.

2001 онд тус банкны хувьд тэмдэглүүштэй чухал үйл явдлууд тохиолдсон нь олон улсын нэр хүнд бүхий “The Banker” сэтгүүлээс тус банкныг “2001 оны Монгол улсын шилдэг банк”-аар тодруулсан явдал болон тус банк олон улсын төлбөр тооцооны нэр хүнд бүхий “VISA International” байгууллагын гишүүн болсон бөгөөд өөрийн оронд уг картын үйлчилгээг нэвтрүүлэхэд шаардлагатай бүх арга хэмжээг богино хугацаанд багтаан гүйцэтгэж чадсан явдал болно. Эдгээр нь бидний ажил, хөдөлмөрийн үр дүн, тус банкны нэр хүндийг дотоодод төдийгүй олон улсын түвшинд хүлээн зөвшөөрч байгааг илэрхийлсэн үйл явдал болсон гэдгийг тэмдэглэхэд таатай байна.

Тайлант онд тус банкны ололт амжилтыг толилуулах боломж гарсан энэ завшааныг ашиглан банкны хувь нийлүүлэгчид, удирдлага, нийт ажиллагсад болон бидэнд итгэл найдвар хүлээлгэж, харилцан ашигтай хамтран ажиллаж байгаа эрхэм харилцагчид Та бүхэндээ чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Цаашид ч бид хамтын ажиллагаагаа өргөжүүлж, харилцан ашигтай ажиллах замаар ололт амжилтаа улам бататган, аливаа саад бэрхшээлийг хамтдаа даван туулж “Хөгжил дэвшилд хамтдаа” хүрэхийн өлзийтэй ерөөлийг та бүхэндээ өргөн дэвшүүлье.

Хүндэтгэсэн,



С. Мөнхбат
Гүйцэтгэх захирал

УРИА

ХӨГЖИЛ ДЭВШИЛД ХАМТДАА

Эрхэм дээд зорилго

Худалдаа, хөгжлийн банк нь Монгол улсын санхүүгийн зах зээлд тэргүүлэх байр суурьтай, нийтлэг үйл ажиллагаатай, хувийн өмчид тулгуурласан, нэр хүнд бүхий арилжааны банк байна. Энэхүү эрхэм зорилго нь банкны найдвартай байдал, харилцагчдын эрэлт хэрэгцээнд нийцсэн, өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн, үйлчилгээ, ажилтнуудын өндөр ур чадвар, тогтвортой ашигт ажиллагаагаар тодорхойлогдоно.

Стратегийн зорилт

Зах зээлд эзэлсэн байр сууриа
хадгалж, бэхжүүлэх

Зах зээлд зохицсон шинэчлэл
хийж, байр сууриа тэлэх

Төрийн өмчийн оролцоог
бууруулах

Банк нь эрхэм дээд зорилгодоо хүрэхийн тулд гадаад орчин, түүний хөгжлийн хандлагыг тусган зохицох, гадаад болон дотоод орчинд хийсэн дүн шинжилгээнд тулгуурлан давуу талаа баталгаажуулах, шинэ давуу тал олж авах, сул талаа багасгах замаар дараахь стратегийн үндсэн чиглэлийг баримтлан хэрэгжүүлнэ.

Стратеги

Арилжааны банкуудын төрийн өмчийг хувьчлах бодлогын хүрээнд банкныг оновчтой арга замаар хувьчлуулах

Банкны бүтэц, зохион байгуулалтыг стратегийн зорилтод нийцүүлэн боловсронгуй болгох

Банкны мэдээллийн технологийг олон улсын стандартад нийцүүлэн хөгжүүлэх

Хүний нөөцийн удирдлагыг олон улсын банкуудын жишигт ойртуулан сайжруулж, сургалтын бодлогыг банкны стратегийн үндсэн зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглүүлэх

Банкны эрсдэлийн удирдлагыг сайжруулах

Найдвартай, том харилцагчдаа хадгалан үлдэхийн зэрэгцээ дунд хэмжээний харилцагчдыг нэмж татах

Банкны бүтээгдэхүүн, үйлчилгээг харилцагчдын эрэлт хэрэгцээнд нийцүүлэн боловсронгуй болгож, шинийг нэвтрүүлэх


Зах зээлийн хөгжил сайтай, дэд бүтэц хөгжсөн орон нутагт банкны салбар, тооцооны төвүүдийг шинээр байгуулах

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ


	2001*	2000
ДНБ /Төгрөгөөр/	1,130.5 тэрбум төгрөг	1,040.0 тэрбум төгрөг
ДНБ /ам.доллараар/	1,029.95 сая ам.доллар	950.8 сая ам.доллар
ДНБ-ний өсөлт	1.1 %	1.1 %
ДНБ-д төсвийн алдагдлын эзлэх хувь	14.7 %	6.1 %
ДНБ-д банкны системийн нийт активын эзлэх хувь	29.4 %	21.7 %
Инфляци	11.2 %	8.1 %
Гадаад худалдааны эргэлт	940.0 сая ам.доллар	1,006.5 сая ам.доллар
Экспорт	385.2 сая ам.доллар	432.3 сая ам. доллар
Импорт	554.8 сая ам.доллар	574.2 сая ам.доллар
Малын тоо	26.1 сая	30.1 сая
Ажилгүйдлийн түвшин	4.7 %	4.5 %

*Тайлбар: Урьдчилсан тооцоо


ДНБ-ний ЖИЛИЙН ӨСӨЛТ /%/




АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ /1995 оны зэрэгцүүлэх үнээр, тэрбум төгрөг/



ИНФЛЯЦИ /Жилийн өөрчлөлт, %/



БАНК, САНХҮҮГИЙН СИСТЕМ.



БАНК, САНХҮҮГИЙН СИСТЕМ.

Монгол улсад 2001 оны эцсийн байдлаар арилжааны 15 банк, үүнээс төрийн өмчийн оролцоотой 6, хувийн 9 банк, банк бус санхүүгийн 26 байгууллага үйл ажиллагаа явуулж байна.

Манай орны нийгэм, эдийн засгийн байдал харьцангуй тогтворжиж иргэдийн банкинд итгэх итгэл төлөвшиж эхэлсэн нь банкны салбарт үүссэн хямралыг даван туулахад эерэгээр нөлөөллөө.

Тайлант онд банк, санхүүгийн системийг эрүүлжүүлэх, өрсөлдөөнийг бий болгох, санхүүгийн секторыг хөгжүүлэх зорилгоор Монголбанкнаас банк бус санхүүгийн байгууллагын үүрэг оролцоог нэмэгдүүлэх бодлого баримталж, энэ чиглэлийн үйл ажиллагаа явуулах хууль эрх зүйн орчинг бүрдүүлснээр тайлант онд гадаад, дотоодын хөрөнгө оруулалттай хэд хэдэн банк бус санхүүгийн байгууллага нэмэгдэж үйл ажиллагаагаа явуулж эхэллээ.

Мөн арилжааны 3 банк Монголбанкнаас зөвшөөрөл авч үйл ажиллагаа явуулж эхэлсэн нь өнөөгийн банк санхүүгийн систем дэх өрсөлдөөнийг нэмэгдүүлж бизнес эрхлэгчдэд илүү таатай орчинг бүрдүүлэхэд тус дөхөм болов.

Тайлант онд банк, санхүүгийн системд гарсан нэг томоохон үйл явдал бол гадаадын хөрөнгө оруулалттай банк байгуулагдан, үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн явдал юм. Энэ нь Монгол улсад банкны шинэ тогтолцоо бүрэлдэн бий болсноос хойш банкны системд анхны гадаадын хөрөнгө оруулалт орж ирснээрээ онцлог юм.

Монгол Улсын засгийн газраас нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх, ялангуяа банк, санхүүгийн эрүүл орчныг бүрдүүлэх үүднээс төрийн өмчийн шууд болон шууд бус оролцоотой банкуудыг хувьчлах банкны хувьчлалын талаар төрөөс баримтлах үндсэн чиглэлийн төслийг Монгол Улсын Их хуралд өргөн барьж, уг баримт бичгийг батлуулсан билээ. Үүнтэй холбогдуулан Монгол улсын Засгийн газраас төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой банкуудын хувьчлалыг бэлтгэж эхэлсэн бөгөөд зарим банкны хувьчлалын бэлтгэл ажил үндсэндээ дуусах шатандаа орлоо.

Монголбанкнаас 2001 онд үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгийн тогтвортой байдлыг хангахад гол анхаарлаа хандуулж ажилласан бөгөөд тайлант оны эцсийн байдлаар төгрөгийн ам.доллартой харьцах ханш 1,102.0 төгрөг болсон бөгөөд 2000 оны сүүлээс хойш 1,100.0 төгрөг орчимд тогтмол байлаа.

Монголбанкн дахь гадаад валютын цэвэр нөөц өмнөх оны мөн үеэс 15.2 хувиар өсч, 162.1 сая ам.долларт хүрсэн нь манай улсын 15.2 долоо хоногийн импортын хэрэгцээтэй тэнцэж байна.

2000 оны мөн үеэс иргэд, байгууллагын төгрөгийн хадгаламж 48.4 хувь буюу 28.6 тэрбум төгрөгөөр, гадаад валютын хадгаламж 40.0 хувь буюу 13.3 тэрбум төгрөгөөр тус тус өсчээ. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн банкинд дахь төгрөг болон гадаад валютын хадгаламж өмнөх оноос 45.2 хувиар өссөн нь ард иргэд, бизнес эрхлэгчдийн банкинд итгэх итгэл өссөнийг харуулахын зэрэгцээ банкуудын санхүүгийн зуучлал гүнзгийрч байгааг илтгэж байна.

Арилжааны банкуудын активын байдал

2001 оны 12-р сарын 31-ний байдлаар арилжааны банкуудын нийт активын 10.4 хувийг банкны нөөц, 15.0 хувийг Төв банкны үнэт цаас, 15.7 хувийг гадаад актив, 9.8 хувийг засгийн газраас авах авлага, 38.5 хувийг аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон цэвэр зээл, 10.6 хувийг бусад актив тус тус эзэлж байна. Оны эцсийн байдлаар банкуудын эзэмшиж буй төв банкны үнэт цаас 117.4 хувиар буюу 26.8 тэрбум төгрөгөөр, банкны нөөц 8.2 хувиар буюу 2,6 тэрбум төгрөгөөр, цэвэр зээлийн өрийн үлдэгдэл 135.4 хувиар буюу 73,7 тэрбум төгрөгөөр, бусад актив 54,1 хувь буюу 12.4 тэрбум төгрөгөөр тус тус өссөн бол гадаад актив 1.8 хувь буюу 0.97 тэрбум төгрөгөөр, Засгийн газраас авах авлага 19.0 хувь буюу 7.6 тэрбум төгрөгөөр тус тус буурчээ.

Актив

Банкны системийн хураангуй тайлан /сая төгрөг/

	2001	2000	Өөрчлөлт%
Банкны нөөц	34,606.2	31,996.4	8.2
Төв банкны үнэт цаас	49,674.9	22,846.7	117.4
Гадаад актив	52,338.6	53,313.0	(1.8)
Засгийн газраас авах авлага	32,457.8	40,059.5	(19.0)
АА-н нэгжүүдээс авах авлага	128,211.4	54,475.9	135.4
Бусад актив	35,442.1	23,000.6	54.1
Нийт актив	332,730.9	225,692.1	47.4

Арилжааны банкуудын пассивын ба өөрийн хөрөнгийн байдал

2001 оны 12-р сарын 31-ний байдлаар арилжааны банкуудын нийт пассивын 26.2 хувийг харилцах, 40.5 хувийг хадгаламж, 2.7 хувийг гадаад пассив, 10.8 хувийг Засгийн газрын хадгаламж, 5.7 хувийг бусад пассив тус тус эзэлж байна.

Өмнөх оны мөн үеэс иргэд, байгууллагын төгрөгийн хадгаламж 48.4 хувь буюу 28.6 тэрбум төгрөгөөр, гадаад валютын хадгаламж 40.0 хувь буюу 13.3 тэрбум төгрөгөөр тус тус өсчээ. Төгрөгийн хадгаламжийн өсөлт валютын хадгаламжийн өсөлтөөс 2.1 дахин их байгаа нь ард иргэд, байгууллага үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгт итгэх итгэл сэргэж байгааг харуулж байна.


Арилжааны банкуудын өөрийн хөрөнгө 2000 оныхтой харьцуулахад 57.5 хувиар буюу 17.2 тэрбум төгрөгөөр өссөн нь хэдийгээр арилжааны банкны үйл ажиллагаа сайжирсныг харуулах боловч нэг талаар 2001 оны хагасаас арилжааны банкны дүрмийн сангийн доод үлдэгдэл 2.0 тэрбум төгрөг болгох журам хэрэгжиж эхэлсэн, нөгөө талаас шинээр арилжааны банкууд үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн зэрэг хүчин зүйлүүд өсөлтөнд нөлөөлсөн.

Пассив ба өөрийн хөрөнгө

Банкны системийн хураангуй тайлан /сая төгрөг/

	2001	2000	Өөрчлөлт %
Харилцах данс	87,296.2	65,223.1	33.8
Төгрөгийн	46,994.6	29,841.5	57.5
Валютын	40,301.5	35,381.5	14.0
Хадгаламж	134,607.4	92,686.2	45.2
Төгрөгийн	87,590.4	59,004.3	48.4
Валютын	47,017.1	33,681.9	40.0
Гадаад пассив	8,823.9	5,866.2	50.4
Засгийн газрын хадгаламж	35,926.8	24,607.1	46.0
Бусад пассив	18,903.6	7,362.0	157.0
Нийт пассив	285,557.9	195,744.5	46.0
Өөрийн хөрөнгө	47,173.0	29,947.6	57.5
Нийт пассив ба өөрийн хөрөнгө	332,730.9	225,692.1	47.4


Банкны системийн гол үзүүлэлтүүд



2001 оны 12-р сарын 31-ний байдлаар тус банкны зах зээлд эзлэх байр суурийг үзүүлбэл:

Үзүүлэлт Арилжааны банкууд	Нийт тэнцэл (%)	Харилцах, хадгаламжийн дансны үлдэгдэл (%)	Нийт зээлийн өрийн үлдэгдэл (%)	Гадаад актив (%)
Худалдаа, хөгжлийн банк	33.6	42.4	26.0	67.0
Бусад	66.4	57.6	74.0	33.0


Нийт тэнцэл



Гадаад актив



Харилцах, хадгаламжийн дансны үлдэгдэл



Зээлийн өрийн үлдэгдэл



ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНКНЫ ТАЙЛАН ТЭНЦЭЛ



Кёкүшюзан сангаас Монгол улсын эдийн засагт оруулсан хувь нэмрийг нь үнэлж “Монголын төлөө өргөмжлөл” олгосон.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНКНЫ ТАЙЛАН ТЭНЦЭЛ

Тайлант онд тус банкны тэнцлийн нийт хэмжээ 111,782.1 сая төгрөгт хүрч, өнгөрсөн оноос 14.8 хувиар буюу 14,372.2 сая төгрөгөөр нэмэгдсэн.


Активын байршлыг оновчтой болгох, бизнес эрхлэгчдийг зээлээр дэмжих зорилгоор зээлийн нийт активт эзлэх хувийн жинг нэмэгдүүлснээр 2001 оны эцсийн байдлаар зээлийн өрийн үлдэгдэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 59.0 хувь буюу 12,342.6 сая төгрөгөөр өссөн байна.

2001 онд гадаад зах дээрх ам.долларын хадгаламжийн хүү эрс буурсантай холбогдуулан тус банк хүүгийн орлого өндөр Засгийн газрын бонд болон Монголбанкны үнэт цаасны активыг нэмэгдүүлэх замаар активын өгөөжийг сайжруулж, төлбөрийн чадварыг төв банкнаас тавьдаг шаардлагын хэмжээнд байлгах бодлого баримтлан ажилласны үр дүнд тайлант оны эцэст үнэт цаасны үлдэгдэл 63.3 хувиар өсч оны эцэст 26,761.4 сая төгрөг, гадаадын банкинд байршуулсан харилцах, хадгаламжийн үлдэгдэл өнгөрсөн оноос 10.0 хувиар буурч 35,078.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан.

Харилцагчдын харилцах, хадгаламж дансны үлдэгдлийн хэмжээ 2000 онтой харьцуулахад 20.75 хувь буюу 16,183.8 сая төгрөгөөр өссөн. Бусад пассив 87.1 хувь буюу 552.4 сая төгрөгөөр буурсан нь татварын өглөг 564.7 сая төгрөгийг төлсөнтэй холбоотой.

	2001	2000	Өөрчлөлт
	мян.төг.	мян.төг.	%
Актив			
Бэлэн мөнгө, богино хугацаат нөөц	7,911,306	13,074,746	(39.5)
Санхүүгийн бусад байгууллага дахь харилцах, хадгаламж	35,078,078	38,921,400	(10.0)
Үнэт цаасанд оруулсан хөрөнгө оруулалт	26,761,404	16,390,466	63.3
Зээл ба урьдчилгаа	33,347,800	21,005,164	59.0
Засгийн газрын үнэт цаас	395,594	866,749	(54.3)
Бусад актив	837,075	379,974	120.3
Үл хөдлөх хөрөнгө, техник тоног төхөөрөмж	7,450,861	6,771,411	10.03
Нийт актив	111,782,118	97,409,910	14.8
Пассив			
Харилцагчдын харилцах, хадгаламж	94,164,393	77,980,552	20.75
Санхүүгийн бусад байгууллагуудын харилцах, хадгаламж	2,632,157	1,501,424	75.3
Гадаадын банкнаас авсан зээл	3,659,213	3,549,352	3.1
Ногдол ашгийн өглөг	410,880	-	-
Бусад пассив	81,568	633,985	(87.1)
Нийт өөрийн хөрөнгө	10,833,907	13,744,597	(21.2)
Нийт пассив ба өөрийн хөрөнгө	111,782,118	97,409,910	14.8

Тайлан тэнцлийн гол үзүүлэлтүүд



Санхүүгийн үр дүн

Тайлант онд тус банк нийт 16,415.5 сая төгрөгийн орлого олж, 7,157.3 сая төгрөгийн зардал гарган, улсын төсөвт 4,359.4 сая төгрөгийн аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татвар төлж, 4,898.8 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллав.

Санхүүгийн үр дүнгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	2001 сая. төг.	2000 сая.төг.	Өөрчлөлт %
Нийт орлого	16,415.5	16,101.9	1.9
Нийт зардал	7,157.3	4,930.5	45.2
Татварын өмнөх ашиг	9,258.2	11,171.4	(17.2)
Татвар	4,359.4	4,573.9	(4.7)
Цэвэр ашиг	4,898.8	6,597.5	(25.8)

Нийт орлого

Тус банк өнгөрсөн 2001 онд нийт 16,415.5 сая төгрөгийн орлого олсон нь 2000 оныхоос 1.9 хувиар буюу 313.6 сая төгрөгөөр их байна.

Нийт зардал

Тайлант хугацаанд нийт 7,157.3 сая төгрөгийн зардал гаргасан нь 2000 оны зардлаас 45.2 хувь буюу 2,226.8 сая төгрөгөөр өссөн байна.

Нийт зардлын өсөлтөнд 1,081.7 сая төгрөгийн хүүгийн зардал, 427.0 сая төгрөгийн болзошгүй алдагдлын зардал, 584.7 сая төгрөгийн боловсон хүчний зардлын өсөлт голлох нөлөө үзүүлсэн байна.


Хүүгийн цэвэр орлого

Тайлант онд тус банкны хүүгийн цэвэр орлого 8,092.3 сая төгрөгт хүрсэн нь өнгөрсөн оноос 5.2 хувь буюу 440.4 сая төгрөгөөр буурсан байна.

Гадаад зах зээл дэх ам.долларын хадгаламжийн хүү эрс буурсан, гадаад, дотоодын арилжааны хувийн банкууд болон банк бус санхүүгийн байгууллагууд шинээр байгуулагдаж зах зээлийн өрсөлдөөнийг нэмэгдүүлсэн, зээлийн хүү, төв банкны үнэт цаасны хүү буурсан зэрэг өөрчлөлтүүд нь банкны цэвэр хүүгийн зөрүүг бууруулсан хэдий ч тус банк зээл олголтыг нэмэгдүүлснээр хүүгийн орлогоо нэмэгдүүлж чадсан.

2000 оны дундажтай харьцуулахад тайлант онд тус банкны төгрөрийн зээлийн хүү 7,2 пункт, валютын зээлийн хүү 1,2 пункт, гадаад зах зээл дээрх хадгаламжийн хүү 3.5 пункт, Монголбанкны үнэт цаасны хүү 4.4 пунктээр тус тус буурсан байна.

Хүүний орлогын бүтэц




Хүүгийн зардал

Хүүгийн зардал өнгөрсөн оноос 70.8 хувь буюу 1,081.7 сая төгрөгөөр өссөн нь хадгаламж эзэмшигчдийн тоо болон харилцах, хадгаламжийн дансны үлдэгдлийн өсөлттэй холбоотой байна.


2000 оны мөн үетэй харьцуулахад тайлант онд харилцах, хадгаламжийн дансны үлдэгдэл 20.75 хувиар буюу 16.2 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн. Тайлант онд бусад зардлын өсөлтөнд, 631.2 сая төгрөгийн төв банкинд байршуулсан салбар банкуудын хадгаламжид дотоод хүү хэлбэрээр хүүгийн зардал төлж эхэлснийг нягтлан бодох бүртгэлд тусгасан нь нөлөөлжээ.

Хүүгийн зардлын бүтэц

2001



2000



Хүүгийн бус орлого


Тайлант онд хүүгийн бус орлого өнгөрсөн оноос 5.4 хувь буюу 327.7 сая төгрөгөөр буурсан.

Хүүгийн бус орлогын бууралтанд бусад орлогын 543.3 сая төгрөгийн бууралт нь голлох нөлөөг үзүүлсэн.


Хэдийгээр хүүгийн бус орлого буурсан ч гадаад зах дээрх валютын арилжааны үйл ажиллагааг идэвхжүүлсний үр дүнд 1.1 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан.

Хүүгийн бус орлогын бүтэц

2001



2000



Үйл ажиллагааны зардал

Банкны үйл ажиллагааны зардал өнгөрсөн оноос 21.5 хувь буюу 718.1 сая төгрөгөөр өссөн. Банкны үйлчилгээ, үйл ажиллагааны цар хүрээ өргөжихийн хирээр ажиллах хүчний тоо өссөн бөгөөд үүнтэй холбоотойгоор боловсон хүчний зардал өссөн байна. Энэхүү зардлын өсөлт нь үйл ажиллагааны зардлын өсөлтөнд голлох нөлөө үзүүлсэн байна.

Болзошгүй эрсдлийн зардал

Болзошгүй эрсдлийн зардал 491.6 сая төгрөг болсон нь 2000 оны мөн үеийнхээс 427.0 сая төгрөгөөр их байна.

ӨӨРИЙН ХӨРӨНГӨ, ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ӨГӨӨЖ

Тайлант онд тус банкны өөрийн хөрөнгө өнгөрсөн оноос 21.2 хувиар буюу 2,910.7 сая төгрөгөөр буурсан нь хуримтлагдсан ашиг өнгөрсөн оноос 37.5 хувиар буюу 3,410.7 сая төгрөгөөр буурсантай холбоотой.

	2001	2000
	мян.төг.	мян.төг.
Дүрмийн сан	2,000,000	1,500,000
Нөөцийн сан	3,152,619	3,152,619
Хуримтлагдсан ашиг	5,681,288	9,091,978
Нийт өөрийн хөрөнгө	10,833,907	13,744,597

Арилжааны банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээг Монголбанкнаас 10 хувиас доошгүй байхаар тогтоосон байдаг бөгөөд тус банкны хувьд өөрийн хөрөнгийн хүрэлцээ 2001 оны 12-р сарын 31-ний байдлаар банкны 1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн харьцаа 12.7 хувь, эрсдлээр жигнэсэн хөрөнгийн харьцаа 15.7 хувь байна.

	2001	2000
	мян. төг	мян. төг
1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө	7,681,288	10,591,978
2-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө	1,798,025	1,672,150
Нийт хөрөнгийн дүн	9,479,313	12,264,128
Эрсдлээр жигнэгдсэн хөрөнгө	124,474,675	98,585,255

	2001	2000
1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө	12.7	27.9
Эрсдлээр жигнэгдсэн хөрөнгийн харьцаа	15.7	32.3

Санхүүгийн үр ашгийн үзүүлэлтүүд

	2001	2000
Өөрийн хөрөнгийн өгөөж	68.5%	111.4%
Активын өгөөж	4.4%	6.8%
Нийт зардал/орлогын харьцаа	43.6%	30.6%

Тайлант онд банкны өөрийн хөрөнгийн өгөөж 68.5 хувь, активын өгөөж 4.4 хувь, нийт зардлын нийт орлогод эзлэх хувийн жин 43.6 хувь байна.


Бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө

Банкны бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ өнгөрсөн оноос 20.8 хувиар буюу 16,183.8 сая төгрөгөөр өсч 94,164.4 сая төгрөгт хүрсэн.

Харилцагчдын харилцах, хадгаламжийн дансны үлдэгдлийг бүтцээр нь авч үзвэл тайлант оны эцэст аж ахуйн нэгж, иргэдийн харилцах 70.32 хувь, иргэдийн хугацаагүй хадгаламж 11.27 хувь, иргэдийн хугацаатай хадгаламж 14.58 хувь, бусад хадгаламж 3.83 хувийг тус тус эзэлж байна.

2001 онд хадгаламжийн дансны үлдэгдэлд төлөх хүү гадаад валютын хадгаламжийн хувьд өөрчлөгдөөгүй харин төгрөгийн хадгаламжийн хүү 2000 онтой харьцуулахад буурсан хэдий ч уг дансны үлдэгдэл тогтвортой өсч, 2000 оны эцсээс 13.8 хувиар буюу 2.96 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн бүтэц



Банкны шалгуур үзүүлэлт

Тайлант онд Монголбанкнаас тогтоосон арилжааны банкны шалгуур 6 үзүүлэлтийг үндсэнд нь хангаж ажилласан. Эдгээр шалгуур үзүүлэлтүүдийг оны эцэст хэрхэн хангаж ажилласныг дараахь хүснэгтээр харуулав.

№	Шалгуур үзүүлэлтүүд	2001.12.31
1.	1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээ $\geq 5\%$	12.7%
2.	Өөрийн хөрөнгийн хүрэлцээ $\geq 10\%$	15.7%
3.	Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар $\geq 18\%$)	62.4%
4.	Гадаад валютын эрсдэл $< +40\%$	31.4%
5.	Нэг зээлдэгчид олгосон зээл / өөрийн хөрөнгө $< 20\%$	20.7%
6.	Өөрийн ажилтанд олгосон зээл / өөрийн хөрөнгө $< 5\%$	0.5%

Заавал байлгах нөөц Тус банк тайлант онд Монголбанкнаас тогтоосон заавал байлгах нөөцийн хангалтыг биелүүлэн, харилцагчдын төлбөр тооцоог цаг тухайд нь гүйцэтгэж ирлээ.

ХАРИЛЦАГЧИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Өнгөрсөн 2001 онд банкны салбар харьцангуй тогтвортой байж, банк санхүүгийн систем дэх өрсөлдөөн ихээхэн нэмэгдсэн жил байлаа. Тайлант жилд гадаад, дотоодын хэд хэдэн банк, банк бус санхүүгийн байгууллага байгуулагдан үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Энэ нөхцөлд бид банкны удирдлага, бүтэц зохион байгуулалтаа боловсронгуй болгох эхлэлийг тавьж, хөрөнгийн эрсдэл, санхүүгийн удирдлагыг сайжруулах, боловсон хүчний мэдлэг, боловсролыг дээшлүүлэх зэрэгт ихээхэн анхаарал хандуулж ажилласны үр дүнд зах зээлд эзлэх байр сууриа бэхжүүлж чадсан юм.


Тайлант онд тус банк үйлчилгээнийхээ чанарыг сайжруулах, харилцагчдын анхны шаардлагаар төлбөр тооцоог нь гүйцэтгэх зорилгоо ханган ажилласны зэрэгцээ харилцагчдынхаа бизнесийн үйл ажиллагааг дэмжих, өрсөлдөөнд дасан зохицож хуучин харилцагчдаа хэвээр хадгалж үлдэх, шинээр харилцагч татах зорилгоор зарим нэр төрлийн үйлчилгээнийхээ хүү, шимтгэлийн хувийг бууруулав.

Тус банк тайлант онд харилцагчиддаа зээл олгох, хадгаламж авах, гадаад, дотоод төлбөр тооцоо хийж гүйцэтгэх, алтны болон валютын арилжаа хийх, экспорт, импортын аккредитив, инкассын үйлчилгээ, баталгаа гаргах, төрөл бүрийн замын болон нэрийн чек худалдах, худалдан авах, төлбөрийн болон кредит картаар үйлчлэх, харилцагчдын үнэт зүйлс, бичиг баримтыг найдвартай хадгалах “Хадгаламжийн хайрцгийн үйлчилгээ”, мөн иргэдийн хувийн гуйвуулгыг дэлхийн 130 гаруй оронд 10 минутын дотор хүлээн авагчид нь найдвартай хүргэх “Иргэдийн гадаад гуйвуулгын үйлчилгээ” (MoneyGram International money transfers) зэрэг уламжлалт үйлчилгээгээ үзүүлэхийн зэрэгцээ Олон улсын нэр хүнд бүхий “VISA International” байгууллагатай хамтран өөрийн нэрийн “VISA” карт гарган үйлчлүүлэгч, харилцагчиддаа барилаа.

ХАРИЛЦАГЧИД



ХАДГАЛАМЖ ЭЗЭМШИГЧИД



2001 оны эцсийн байдлаар нийт 10,189 харилцагч байгууллага, 3,023 хувийн харилцах данстай иргэд, 9,060 хадгаламж эзэмшигчидтэй байгаа нь 2000 оны мөн үеийнхээс харилцагч байгууллага 8.0 хувь буюу 784, хувийн харилцахтай иргэд 25.0 хувь буюу 599, хадгаламж эзэмшигчид 37.0 хувь буюу 2,451-ээр тус тус нэмэгдсэн байна.

Тайлант жилийн эцэст банк 22,272 харилцагч, хадгаламж эзэмшигчдэд 25,000 гаруй дансаар үйлчилж байгаагийн зэрэгцээ гадаадын 30 гаруй орны 141 банктэй корреспондентийн харилцаатай ажиллаж, тэдгээрээр дамжуулан харилцагчдынхаа гадаад төлбөр тооцоог олон улсын банк хоорондын Свифт сүлжээг ашиглан шуурхай гүйцэтгэж байна.

ЗЭЭЛ

Зээлийн бодлого

Монгол улсын засгийн газраас 2001 оныг үндэсний үйлдвэрлэлийг дэмжих жил болгон зарласан явдал нь тус банкныг бодит эдийн засгийг, ялангуяа үйлдвэрлэлийн үйл ажиллагааг санхүүжүүлэх, зээлээр дэмжихэд зээлийн бодлогоо түлхүү хандуулахад нөлөөлсөн.

Энэ бодлогын хүрээнд тус банк зээлийн хүүгээ бууруулах болон зээл олголтыг нэмэгдүүлэх гэсэн 2 үндсэн зорилтот арга хэмжээнд зээлийн бодлогоо чиглүүлсэн бөгөөд үүний үр дүнд зээл олголт өмнөх 2000 онтой харьцуулахад бараг 2 дахин өсч 86.6 тэрбум төгрөгт, зээл эргэн төлөлт 83.6 хувиар нэмэгдэж 75.1 тэрбум төгрөгт, зээлийн цэвэр өрийн үлдэгдэл 58.8 хувиар өсөж 33.3 тэрбум төгрөгт хүрсэн.

Нөгөө талаар зээлийн хүү өнгөрсөн онтой харьцуулахад төгрөгийн зээлийн хувьд 7.2 пунктээр, валютын зээлийн хувьд 1.2 пунктээр тус тус буурсан байна.

Мөн түүнчлэн үйлдвэрлэлийг дэмжих, экспортыг урамшуулах төрийн бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд зэс, алт олборлодог компаниудад эрсдлийн үнэлэмж тогтоосны үндсэн дээр ердийнхөөс бага хүүтэйгээр зээл олгох шинэ тогтолцоог бүрдүүлсэн.

Зээлийн багцын чанарыг дээшлүүлэх зорилгоор зээлийн эрсдлийн удирдлага, урьдчилсан ба дараалсан хяналтыг сайжруулах, зээлийг хугацаанд нь төлүүлэх, хугацаа хэтрэлтээс урьдчилан сэргийлэх, чанаргүй зээлийг төлүүлэхэд голчлон анхаарч зохих арга хэмжээ авч ажилласны үр дүнд чанаргүй зээлийн өрийн үлдэгдлийг 804.3 сая төгрөгөөр буюу 12.3 хувиар, түүний дотор муу зээлийн өрийн үлдэгдлийг 39.0 хувиар буурууллаа.

Дээр дурьдсанчлан тус банк алт, зэс, жонш олборлолт, ноолуур, махны экспорт, гурилын үйлдвэрлэл, нефть импорт, эрчим хүч, тээвэр холбооны зэрэг манай улсын эдийн засагт нөлөө бүхий, тус банктай тогтвортой харилцаатай аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг зээлээр дэмжихэд түлхүү анхаарч ажиллалаа.

Монгол улс болон ХБНГУ-ын Засгийн газар хооронд манай улсын хувийн хэвшлийн хөгжлийг дэмжих зорилгоор 1995 онд байгуулагдсан хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийн хүрээнд тус банк 2001 оны эцсийн байдлаар нийт 8 аж ахуйн нэгжид 4.7 сая дойч маркийн зээлийг олгосон байна.

Мөн түүнчлэн, тус банк Дэлхийн Банкны Олон Улсын Хөгжлийн Ассоциациас Монгол улсын Засгийн газарт хувийн хэвшлийг дэмжих зорилгоор 1999 онд олгосон зээлийн хөтөлбөрийн хүрээнд тайлант оны эцсийн байдлаар нийт 6 аж ахуйн нэгжид 996.2 мянган ам. долларын дунд болон урт хугацааны зээл олгосон байна.


Олон улсын санхүүгийн байгууллагуудаас Засгийн газарт олгож буй эдгээр зээлийг тус банкнаас аж ахуйн нэгжүүдэд дамжуулан зээлдүүлэхдээ үйлдвэрлэл, үйлчилгээний хөрөнгө оруулалтыг дэмжих чиглэлийг баримталж, үүнтэй холбогдуулан хүүний түвшинг улсын хэмжээнд хамгийн боломжит бага түвшинд тогтоон ажиллаж байна.

2001 оны эцсийн байдлаар ХБНГУ-ын KfW банкнаас манай улсын жижиг, дунд үйлдвэрлэлийн салбарыг дэмжихэд зориулан олгосон зээлийн хүүг тус банкнаас жилийн 7.75 хувь, Дэлхийн Банкны Олон Улсын Хөгжлийн Ассоциациас хувийн хэвшлийг дэмжихэд олгосон валютын зээлийн хүүг жилийн дунджаар 10.5 хувиар тус тус тооцож ирлээ.

Зээлийн багц

Энэ онд нийт 86.6 тэрбум төгрөгийн /үүнээс 86.4 тэрбум төгрөгийг өөрийн эх үүсвэрээр/ зээл олгосны 62.9 хувийг үйлдвэрлэлийн салбарт олгосон байна. Үйлдвэрлэлийн салбарт олгосон нийт зээлийн 29.7 хувийг ноос, ноолуур, гурил, эрчим хүч зэрэг боловсруулах үйлдвэрүүдэд, 66.0 хувийг уул уурхайн олборлох үйлдвэрүүдэд, 3.4 хувийг барилгын салбарт, үлдэх хувийг хөдөө аж ахуйн салбарт олгосон байна.

ЗЭЭЛИЙН ӨРИЙН ҮЛДЭГДЛИЙН БҮТЭЦ 2001.12.31



Энэ онд тус банкны олгосон зээл өнгөрсөн онтой харьцуулбал 84.2 хувиар өссөн бол, зээл эргэн төлөлт 83.6 хувиар нэмэгдэж 75.1 тэрбум төгрөгт хүрсэн байна.

ЗТУБАХамгаалах сан

/сая төгрөг/

	2001	2000	Өөрчлөлт
Чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл	5,664.4	6,468.7	(804.3)
Зээлийн болзошгүй алдагдлын сан	4,743.7	6,669.6	(1,925.9)
Чанаргүй зээл, зээлийн алдагдлаас хамгаалах сангийн харьцаа	0.838	1.03	


Тайлант оны эцэст тус банкны чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл 5,664.4 сая төгрөг, зээлийн болзошгүй алдагдлаас хамгаалах сан 4,743.7 сая төгрөг болсон ба чанаргүй зээл болон түүний алдагдлаас хамгаалах сангийн харьцаа 0.838 хувь байна.

Тус банк энэ онд зээлийн багцыг сайжруулах, чанаргүй зээлийг нөхөн төлүүлэх асуудалд онцгой анхаарал хандуулж, шат дараатай арга хэмжээ авч ажилласны үр дүнд нийт 2.8 тэрбум төгрөгийн чанаргүй зээлийг төлүүлсэн бөгөөд зээлийн багцын чанар өмнөх оныхоос харьцангуй сайжирсан байна.

ГАДААД ТООЦОО

Тус банк нь 2001 онд гадаад төлбөр тооцооны хувьд Монгол улсын арилжааны банкны салбарт тэргүүлэх байр сууриа урьдын адил хадгалан ажилласан. 2001 оны эцсийн байдлаар арилжааны банкуудын нийт гадаад активын 67.0 хувь нь тус банкинд ноогдож байна.

ГАДААД АКТИВТ ЭЗЛЭХ ХУВИЙН ЖИН



Тайлант онд тус банк гадаад гуйвуулга, эх үүсвэртэй, эх үүсвэргүй аккредитив, батлан даалт, валютын арилжаа зэрэг банкны бүтээгдэхүүн, үйлчилгээгээр харилцагчиддаа үйлчилж нийт 1.8 сая ам долларын орлого олсон байна.

Өнгөрч буй 2001 онд харилцагчдын төлбөр тооцоог хурдан шуурхай гүйцэтгэх зорилгоор тус банк СВИФТ СИТА-д холбогдсон бөгөөд ийнхүү холбогдсоноор 24 цагийн турш уг сүлжээнд байнгын горимд ажиллах боломжтой болж мэдээлэл хүлээн авах, илгээх ажиллагаа тасралтгүй болсноос гадна дотоод холбооны зардал хэмнэгдсэн юм.

2001 онд харилцагчдын хүсэлтээр гадаад гуйвуулгыг цаг алдахгүй тухай бүр хурдан шуурхай гүйцэтгэсэн бөгөөд гүйлгээний тоо өмнөх онтой харьцуулахад 17.8 хувиар нэмэгдсэн хэдий ч шимтгэлийг ихээхэн бууруулснаас олох орлогын хэмжээ багассан байна.

Түүнчлэн 2001 оноос тус банк нь ОХУ болон БНХАУ-ын банкууд руу харилцагчдын төлбөрийг гуйвуулахдаа төлбөрийн шууд хэлбэрийг хэрэглэдэг болсноор төлбөрийн өгөгдлүүд хүлээн авагчийн банкинд дутуу очдог, төлбөр замын банкуудад саатдаг зэрэг зарим дутагдлууд ариллаа.

Тайлант онд банкны салбарт тэргүүлэх байр сууриа хадгалах, мөн шинээр харилцагч татах, харилцагчиддаа илүү боломж бий болгох үүднээс гадаад гуйвуулгынхаа шимтгэлийг 20-40 хувиар буурууллаа.

Тус банкны гадаад активын хэмжээ 2001 оны 12-р сарын 31-ний байдлаар 35 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9.8 хувиар буурсан байна. Энэ нь тайлант онд гадаад валютын хадгаламжийн хүү эрс буурсантай холбоотойгоор тус банк татан төвлөрүүлсэн хөрөнгийг активын өгөөж өндөр зээл, Монголбанкны үнэт цаасанд түлхүү байршуулсантай холбоотой.

Гадаад харилцаа

Тус банк гадаад харилцаагаа өргөжүүлэх, уламжлалт харилцааг бэхжүүлэх, гадаадын банк, санхүүгийн байгууллагын дунд өөрийн банкны нэр хүндээ дээшлүүлэхэд чиглэсэн бодлого баримталж ажилласан.

2001 оны байдлаар манай банк 30 гаруй орны 141 банктай корреспондентын харилцаатай, нийт 12 орны 25 банк дахь 31 харилцах дансаараа дамжуулан гадаад төлбөр тооцооны үйл ажиллагаагаа эрхлэн явуулсан.

Тайлант жилд евро нэгжийг бэлэн бус төлбөр тооцоонд нэвтрүүлэх болсонтой холбогдуулан манай банк 1999 оноос Европын зарим банкуудад байсан үндэсний валютын дансыг ЕВРО-д шилжүүлж, хамгийн түрүүнд арилжааны банкуудаас Монгол улсад Евро мөнгөн дэвсгэртээр үйлчилж эхэлсэн.

Мөн 2001 онд тус банкинд HSBC, Сити банк, Коммерц банк болон Дрезднер банкуудаас төлөөлөгчид ирж ажил хэргийн уулзалт хийсэн бөгөөд уулзалтын үр дүнд хамтран ажиллах тодорхой тохиролцоонд хүрээд байна.

Харилцагчдын төлбөрийн гуйвуулгыг хурдан шуурхай гүйцэтгэх, банкны гадаад харилцааг өргөжүүлэх зорилгоор сүлжээ сайтай АНУ-ын Сити банк, ОХУ-ын Хадгаламжийн Банк, Солонгосын Korea Exchange зэрэг банкуудад харилцах данс нээлгэх хүсэлтээ гаргасан бөгөөд оны эцсийн байдлаар Солонгосын Korea Exchange банкинд дансаа нээн, харилцагчдынхаа төлбөр тооцоог шуурхай гүйцэтгэж байна.

Гадаадын банкууд дахь харилцах данс

Банкууд		Дансны дугаар	SWIFT код	
<i>USD</i>	AGRICULTURAL BANK OF CHINA, THE	ERLIAN	1.48211E+12	ABOCCNBJ050
	AMERICAN EXPRESS BANK LTD.	NEW YORK	716332	AEIB US 33
	BANK FOR FOREIGN TRADE (VNESHTORG)	MOSCOW	301128408000000000 63	VTBRRUMM
	BANK OF CHINA	BEIJING	8.00339E+13	BKCHCNBJ
	BANK OF TOKYO-MITSUBISHI LTD. THE	TOKYO	653-0453625	BOTKJPJT
	BANKGESELLSCHAFT BERLIN AG,	BERLIN	00 91094963	BEBEDEBB
	BANQUE COMMERCIALE POUR L'EUROPE			
	DU NORD - EUROBANK	PARIS	-493775	EUROFRPP
	BNP PARIBAS SA	PARIS/HONG KONG	00001083822031USD	BNPAFRPF/HKHH
	CREDIT LYONNAIS S.A.	NEW YORK	01-11231-0001-00	CRLYUS33
	CREDIT SUISSE FIRST BOSTON	ZURICH	0835-0993850-74-002	CRESCHZZ80A
	DEUTSCHE BANK AG	FRANKFURT AM MAIN	100 9552530 0005	DEUTDEFF
	DRESDNER BANK AG	FRANKFURT AM MAIN	499/08104402/00/400	DRESDEFF
	HSBC BANK PLC LONDON(MIDLAND BANK)	LONDON	69145064	MIDLGB22
	HSBC BANK USA	NEW YORK	304298	MRMDUS33
	INTERNATIONAL MOSCOW BANK	MOSCOW	001201442 USD 400302	IMBKRUUM
	JP MORGAN CHASE	NEW YORK	001-1-614823	CHASUS33
	KOREA EXCHANGE BANK, THE	SEOUL	963-THR-287011	KOEXKRSE
	NORDIA MERITA BANK PLC,	HELSINKI	2.0006E+13	MRITFIHH
	NATEXIS BANQUES POPULAIRES	PARIS/SINGAPORE	1295690201	BFCEFRPP/SGSG
	NATIONAL BANK OF HUNGARY (FORMER			
	MAGYAR NEMZETI BANK)	BUDAPEST	2.11103E+12	MANEHUHB
	UNION BANK OF CALIFORNIA INTERNATIONAL	NEW YORK	91-243394-1121	BOFCUS33NYK
<i>JPY</i>	AMERICAN EXPRESS BANK LTD.	TOKYO	245-313000719	AEIB JP JX
	BANK OF TOKYO-MITSUBISHI LTD. THE	TOKYO	653-0439924	BOTKJPJT
<i>GBP</i>	HSBC BANK PLC LONDON(MIDLAND BANK)	LONDON	334567	MIDLGB22
	NATIONAL WESTMINSTER BANK	LONDON	4.4E+12	NWBKGB2L
<i>EUR</i>	BANKGESELLSCHAFT BERLIN AG,	BERLIN	9808786010	BEBEDEBB
	BANQUE COMMERCIALE POUR L'EUROPE			
	DU NORD - EUROBANK	PARIS	00 548011	EUROFRPP
	COMMERZBANK AG	FRANKFURT AM MAIN	400878500801 EUR	COBADEFF
	CREDITANSTALT AG,	VIENNA	0101-15004/00	CABVATWW
	DEUTSCHE BANK AG	FRANKFURT AM MAIN	50070010/95525301000	DEUTDEFF
	DRESDNER BANK AG	FRANKFURT AM MAIN	499/08104402/11/888	DRESDEFF
<i>CNY</i>	AGRICULTURAL BANK OF CHINA, THE	ELRIAN	7.10101E+14	ABOCCNBJ050
<i>CHF</i>	CREDIT SUISSE FIRST BOSTON	ZURICH	0835-0993850-73-000	CRESCHZZ80A
	UBS AG, ZURICH	ZURICH	02300000087421050000L	UBSWCHZH

АЛТ, ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА

Тус банк нь Монголбанкнаас алтны арилжаа хийх зөвшөөрлийг 2000 онд авсан бөгөөд өнөөдрийн байдлаар дотоод, гадаадын зах дээр алт худалдан авах, худалдах, хадгалуулах, хадгалах үйл ажиллагаа явуулах эрхтэй монголын ганц арилжааны банк юм.

Тайлант онд банк алт олборлогч 15 аж ахуйн нэгжээс 3.2 тонн цэвэр алт худалдан авч Монголбанкинд худалдсан бөгөөд энэ нь алт олборлогч аж ахуйн нэгжүүд нийт 13.7 тонн цэвэр алт Монголбанкинд тушаасны 23.4 хувийг эзэлж байна.

Өнгөрч буй 2001 онд тус банк нийт 31.9 тэрбум төгрөгийн алт арилжаалж нэмэгдсэн өртгийн албан татварт 2.9 тэрбум төгрөг, нөөцийн төлбөрт 0.7 тэрбум төгрөгийг тус тус шилжүүлсэн байна.

2001 онд Төв банк нийт 461.8 тэрбум төгрөгийн үнэт цаасыг 7, 14, 28, 91 хоногийн хугацаатай гаргаж арилжааны банкуудад худалдсан байна. Үүнээс тус банк 272.2 тэрбум төгрөгийн үнэт цаас буюу 58.9 хувийг худалдан авч, хоёрдогч зах зээлээс буюу бусад банкуудаас 23.4 тэрбум төгрөгийн үнэт цаас худалдан авчээ. Худалдаа, хөгжлийн банк өнөөдрийг хүртэл арилжааны банкууд дотроос төв банкны үнэт цаасны хамгийн том, идэвхтэй худалдан авагч байсаар байна. Оны эцсийн байдлаар тус банк 21.8 тэрбум төгрөгийн үнэт цаасны үлдэгдэлтэй байсан. Өнгөрсөн оны Төв банкны үнэт цаасны жигнэсэн дундаж хүү 8.6 хувь байсан ба тус банк Төв банкны үнэт цаасны хүүнд нийт 1.2 тэрбум төгрөгийн орлого олсон.

2001 онд Монгол улсын Засгийн газар нийт 40.0 тэрбум төгрөгийн хямдруулсан бондыг 30, 60, 90, 120 хоногийн хугацаатай гаргаж Монголын хөрөнгийн биржээр арилжаалсан. Үүнээс тус банк 21.4 тэрбум төгрөгийн бонд буюу нийт гаргасан бондын 53.5 хувийг нь худалдан авсан. Худалдаа, хөгжлийн банк Засгийн газрын хямдруулсан бондын хүүнд нийт 633.8 сая төгрөгийн орлого олжээ.

ВАЛЮТЫН АРИЛЖАА

2001 онд тус банк своп, опшин, форвард зэрэг санхүүгийн деривативуудыг нэвтрүүлснээр харилцагч байгууллага, хувь хүмүүс болон бусад арилжааны банкууд тус банкаар дамжин олон улсын валютын зах дээр арилжаа хийх бололцоо бүрдсэн. Ийнхүү санхүүгийн деривативуудыг нэвтрүүлсэн нь харилцагчиддаа илүү өргөн санхүүгийн үйлчилгээ үзүүлэх боломжтой болгосны дээр банкны орлогыг нэмэгдүүлэх нэг эх үүсвэр болов.

Монгол улсын хамгийн том арилжааны банкны хувьд тус банк нь дээрх үйлчилгээг өөрийн харилцагчид болон бусад арилжааны банкуудад үзүүлэх техникийн болон санхүүгийн хүчин чадалтай юм.

Арилжаатай холбогдон гарах эрсдлийг бууруулах зорилгоор хадгаламж барьцаалан арилжаа явуулдаг бөгөөд нээлттэй позицгийг өдөр бүр хаадаг. Иймээс эдгээр гэрээ, хэлцлүүд нь валютын ханшийн ямар нэгэн эрсдэл агуулдаггүй болно.

Валютын арилжааны үйлчилгээний нөхцөл, чанарыг сайжруулсны хирээр тайлант жилд харилцагч санхүүгийн байгууллага, компани, хувь хүмүүсийн тоо өссөн бөгөөд үүнтэй холбоотойгоор валютын арилжааны өдрийн эргэлт ч эрс нэмэгдсэн.

Нийт арилжааны эргэлт 2001 онд өнгөрсөн онтой харьцуулахад 190 дахин, мөн арилжааны үйл ажиллагаанаас олсон орлого өссөн бөгөөд цаашид өсөх хандлагатай байна.

Банкны нэрийн өмнөөс хийгддэг арилжаа нь хязгаарлагдмал бөгөөд өдөр бүрийн арилжаа нь зөвшөөрөгдсөн лимитийн дотор хийгддэг. Арилжааны лимитийг хагас жилд нэг удаа эрсдлийг үнэлэх (VAR) арга дээр үндэслэж Актив, пассивийн хорооны хурлаар хэлэлцэж, Гүйцэтгэх захирлын тушаалаар тогтоодог.

ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ

Банк нь харилцагч, хадгаламж эзэмшигч, үйлчлүүлэгчдийнхээ эрэлт хэрэгцээнд нийцсэн, зах зээлд өрсөлдөх чадвар бүхий бүтээгдэхүүн үйлчилгээгээр хангах зорилготойгоор олон улсын нэр хүнд бүхий “VISA International” байгууллагатай хамтран бэлэн бус төлбөр тооцооны хэрэгсэл болох “VISA” картын үйлчилгээг нэвтрүүлсэн.

“VISA” карт



ХХБ нь “VISA International” байгууллагад 2001 оны 2-р сард үндсэн гишүүнээр элсэн орж, 2001 оны 12-р сараас өөрийн нэрийн 4 төрлийн дебит “VISA” карт гаргасан.

Худалдаа, хөгжлийн банкны “VISA” карт эзэмшигчдэд дотоодод Худалдаа, хөгжлийн банкны картаар үйлчлэгч үйлчилгээний 200 байгууллага, мөн хоногийн 24 цагаар ажилладаг Автомат Тооцооны Машин /АТМ/, гадаадад 22 сая үйлчилгээний байгууллага, 630,000 гаруй АТМ-ээр үйлчлүүлэх боломж нээгдлээ.



Тус банк картын үйлчилгээ нэвтрүүлсэнтэй холбоотойгоор Монголд анх удаа АТМ-ийг оруулж ирсэн бөгөөд ингэснээр төлбөрийн картын үйлчилгээг иж бүрнээр нь нэвтрүүлээ.



Мөн тус банкны “VISA” картын үйлчилгээний тариф нь бусад банкны ижил төрлийн үйлчилгээний тарифаас хямд байгаа юм. Хэдийгээр энэхүү үйлчилгээг нэвтрүүлээд удаагүй ч карт эзэмшигчийн тоо их хурдацтай өсч байгаа бөгөөд иргэд байгууллагын хоорондын төлбөр тооцоог хөнгөвчилсөн, хамгийн тохиромжтой, уян хатан, боловсон үйлчилгээ болох нь харагдаж байна.



“VISA International” байгууллагаас “VISA” картыг богино хугацаанд амжилттай нэвтрүүлснийг үнэлж “New market development award” буюу “Шинэ зах зээлд нэвтрүүлэгч” шагнал олгов.



САЛБАР БАНКУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2001 оны санхүүгийн жилд ялангуяа хөдөө орон нутагт олон арилжааны банкуудын салбар, нэгжүүд байгуулагдсан нь тус банкны хувьд үйл ажиллагаагаа өргөжүүлэх, зах зээлийн төлөө өрсөлдөөний жил байлаа.

Тайлант онд салбар банкууд харилцагч байгууллагуудын хэрэгцээ шаардлагыг хангасан бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг үзүүлэх, хот, орон нутгийн эдийн засгийн хөгжлийн түвшинг дэмжих зориулалтаар зээл олголтын үйл ажиллагааг явуулсны дүнд зээл олголт 3.3 дахин нэмэгдсэн байна.

2001 онд харилцагч үйлчлүүлэгчиддээ хүрч ажиллах, шинээр харилцагч татах зорилгоор нийслэлийн Баянгол дүүрэгт, мөн Дархан-Уул аймгийн Дархан суманд тус тус шинээр Тооцооны төв нээж ажиллуулав.


Мөн тайлант онд салбар банкны үйл ажиллагааг өргөжүүлэх, харилцагч үйлчлүүлэгчдэд хүрч ажиллах зорилгоор Дорноговь аймаг дахь 808-р салбар нь харилцагч байгууллага, иргэдэд зээл олголтын үйл ажиллагааг эхэлсэн.

2001 оны эцэст тус банк төв банкнаас гадна 8 салбар банк, 7 тооцооны төв, нэг тооцооны касс ажиллуулснаар банкны үйлчилгээг харилцагчдад ойртуулах, харилцагчдын тоог нэмэгдүүлэх, зах зээлд байр сууриа өргөжүүлэн тэлэх боломжтой болсон юм.


Салбар банкуудын балансын нийт тэнцэл 2001 оны 12-р сарын 31-ний байдлаар 27.2 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оныхоос 12.8 хувиар өсч системийн нийт тэнцлийн 23.8 хувийг эзлэх болсон байна.

Жилийн эцсийн байдлаар салбар банкуудын нийт пассивын 65.7 хувь нь харилцах, 13.7 хувь нь хадгаламж, 4.1 хувь нь гадаад пассив байгаа бол нийт активын 2.4 хувь нь бэлэн мөнгө, 76.2 хувь нь өөрийн төв банкин дахь хадгаламж, 3.7 хувь нь гадаад актив, 13.2 хувь цэвэр зээл, 4.4 хувь нь үндсэн хөрөнгө байна.

САЛБАР БАНКУУДЫН АКТИВЫН БҮТЭЦ



САЛБАР БАНКУУДЫН ПАССИВЫН БҮТЭЦ



Салбар банкууд 2001 оны санхүүгийн жилд заавал байлгах нөөцийг хангах, харилцагчдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийг эрсдэл багатай активт байршуулах, зээл олголт, төлөлтөд тавих хяналтыг сайжруулах, үр ашгийг нэмэгдүүлэх талаар зохих ахиц гаргаж ажиллалаа.

Тайлант онд салбар банкууд 4,744.3 тэрбум төгрөгийн гүйлгээ хийж 3,384.9 сая төгрөгийн орлого олж, 1,229.2 сая төгрөгийн зардал гаргасны дүнд татварын өмнөх орлого 2,152.0 сая төгрөг болсон нь өмнөх оны мөн үеийнхээс нийт орлого 16.1 хувь буюу 468.3 сая, зардал 15.8 хувиар буюу 168.1 сая төгрөгөөр өсч, татварын өмнөх орлого 15.9 хувь буюу 296.6 сая төгрөгөөр өссөн байна.

2001 оны 12-р сарын 31-ний байдлаар салбарт банкуудын балансын нийт тэнцэл өнгөрсөн оны мөн үеийнхээс 12.8 хувиар нэмэгдсэн байна.

БОЛОВСОН ХҮЧНИЙ БОДЛОГО, БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Тус банкны ажилтнуудын өндөр мэдлэг боловсрол, мэргэжлийн ур чадвар бол манай банкны амжилтын гол эх сурвалж юм. Тиймээс ч банкны ажиллах хүчний хангалтыг сайжруулах, үндсэн мэргэжлийн ажилтнуудын эзлэх хувийн жинг нэмэгдүүлэх, тэднийг сургалтанд хамруулж мэдлэг боловсрол, дадлага, туршлагыг нь дээшлүүлэх, цалин хангамж, ахуйн нөхцлийг сайжруулах, банкныхаа эцсийн үр дүнгийн төлөө санаа тавьдаг, хариуцлага хүлээдэг байх тогтолцоонд оруулахад чиглэсэн цогц арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх зэрэг томоохон асуудалд гол анхаарлаа хандуулж ажиллаж ирлээ.

Банкны ажил үйлчилгээний нэр төрөл, цар хүрээ өргөжихийн хирээр албан тушаал тус бүрийн онцлог, хэрэгцээ шаардлагад нийцсэн боловсон хүчнийг сонгон авах, албан тушаалд дэвшүүлэх буюу сэлгүүлэн ажиллуулах зэргээр боловсон хүчний нөхөн хангалтаар нийт 59 ажилтныг шинээр авч ажиллууснаар нийт ажиллагсдын тоо 2001 онд 363 болж өслөө.

	2001	2000
Нийт ажилтнууд	363	323
Үүнээс:		
Төв	239	211
Салбарууд	124	112

Сургалт, семинар

2001 онд банкны ажиллагсдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх, туршлага эзэмшүүлэх, гадаад хэлний мэдлэгийг сайжруулах, мөн үйлчилгээний соёлыг сайжруулах зорилгоор гадаад, дотоодын сургалтанд давхардсан тоогоор 153 хүнийг хамруулсан байна.

Тайлант жилд тус банк Монгол банкны сургалтын төвтэй хамтран арилжааны банкны ажиллагсдын дунд “Гадаад төлбөр тооцоо” сэдвээр сургалт семинар зохион байгуулав.

Мөн 2001 онд бэлэн мөнгөтэй харьцдаг аж ахуйн нэгж байгууллага, хувь хүмүүсийн дунд “Хуурамч долларыг таних арга, евро мөнгөний шинж” сэдвүүдээр сургалт семинар зохион байгуулж давхардсан тоогоор 100 гаруй хүн хамрагдсан байна.

Удирдлагын хороо



Д. Хүрэлбаатар
Дэд захирлын үүрэг гүйцэтгэгч
бөгөөд харилцагчийн үйлчилгээний
газрын захирал

Б. Саран
Тэргүүн дэд захирал

С. Мөнхбат
Гүйцэтгэх захирал

Д. Хулан
Дэд захирал

А. Гансүх
Тамгын газрын захирал

Захирлын зөвлөл



Дээд эгнээ: Зүүн гар талаас

Б. Энхбат
Зээлийн газрын захирал

Ю. Гэрэлмаа
Гадаад тооцооны
газрын захирал

П. Мөнхсайхан
Судалгаа, маркетингийн
газрын захирал

Ө. Хишгээ
Хяналт шалгалтын
газрын захирал

Ц. Болд
Мэдээллийн технологийн
газрын захирал

Р. Оюунбилэг
804-р салбарын
захирал

Д. Батхүү
Аж ахуйн газрын захирал

Доод эгнээ: Зүүн гар талаас

А. Гансүх
Тамгын газрын захирал

Д. Янжмаа
Тайлан бүртгэлийн
газрын захирал

Б. Саран
Тэргүүн дэд захирал


Д. Хулан
Дэд захирал

Д. Хүрэлбаатар
Дэд захирлын үүрэг гүйцэтгэгч
бөгөөд харилцагчийн үйлчилгээний
газрын захирал

ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ

/2001 оны 12 дугаар сарын 31/

Хувь нийлүүлэгчдийн хурал





Банкны хаяг, байршлууд

ТӨВ БАНК

Худалдааны гудамж-7
Улаанбаатар-11, Монгол Улс
Утас: 976-11-327028
Факс: 976-11-311618
www.tdbm.mn

Салбар # 801

Дорнод аймаг,
Чойбалсан сум
Монгол Улс
Утас: (01582) 23009.
Факс: (01582) 23632

Салбар # 802

Сэлэнгэ аймаг,
Сүхбаатар сум
Монгол Улс
Утас: (01362) 22007
Факс: (01362) 23076

Салбар # 803



Дархан-Уул аймаг, Дархан сум
Монгол Улс
Утас: (01372) 33726
Факс: (01372) 37761

Салбар# 804

Энхтайваны гудамж 11-А
Улаанбаатар, Монгол Улс
Утас: 312679
Факс: 312661

Салбар # 805

Замчны гудамж -36
Улаанбаатар, Монгол Улс
Утас: 944867
Факс: 944818

- Тайлбар
-  Төв банк
 -  Салбар банкууд
 - Тооцооны төвүүд
 - Автомат тооцооны машинууд



Тооцооны төв # 6

Ард Аюушын өргөн чөлөө
Улаанбаатар, Монгол Улс
Утас: 361968
Факс: 361975

Дархан-Уул аймгийн

Тооцооны төв

Дархан сум, Монгол улс
Утас: (01372) 23835

Замын -Үүдийн тооцооны төв

Монгол улс
Утас: (015245) 21133
Факс: (015245) 21168

Зүүн хараагийн тооцооны төв

Монгол улс
Утас: (023647) 43903
Факс: (023647) 43903

Тооцооны төв # 2

Худалдааны гудамж-7
Улаанбаатар-11, Монгол Улс
Утас: 312356
Факс: 312356

Тооцооны төв # 3

Бага тойрог- 17,
Улаанбаатар, Монгол Улс
Утас: 313833
Факс: 311994

Салбар # 808

Дорноговь аймаг, Сайншанд сум
Монгол Улс
Утас: (01522) 2298
Факс: (01522) 22298

Тооцооны төв #1

Буянт-Ухаа,
Нисэх онгоцны буудал
Улаанбаатар, Монгол Улс
Утас: 379714
Факс: 379714

Салбар # 806

Чингисийн өргөн чөлөө
Улаанбаатар, Монгол Улс
Утас: 341335
Факс: 341295

Салбар # 807

Орхон аймаг, Баян-Өндөр сум
Монгол Улс
Утас: (01352) 25135
Факс: (01352) 25155

ХӨНДЛӨНГИЙН ХЯНАЛТЫН ТАЙЛАН

Агуулга

- 40 Хөндлөнгийн хяналтын дүгнэлт
- 42 Орлого үр дүнгийн тайлан
- 43 Үлдэгдлийн тэнцэл
- 44 Мөнгөн гүйлгээний тайлан
- 45 Санхүүгийн тайлангийн тайлбар





■ **Certified Public Accountants**
Suite 300, Ikh Toiruu 14
Khoroo 10, Sukhbaatar duureg
Ulaanbaatar 210620, Mongolia

■ Phone: (976-11) 350 137
Fax: (976-11) 350 070
www.ey.com

Аудиторын тайлан

Худалдаа Хөгжлийн Банкинд

Бид Худалдаа Хөгжлийн Банкны санхүүгийн тайлан тэнцэлд (хуудас 42-66) аудит хийж гүйцэтгэлээ.

Банкны удирдлага болон аудиторын хариуцлага

Банкны Төлөөлөн Удирдах Зөвлөл нь санхүүгийн тайлангуудыг бэлтгэх үүрэгтэй. Бидний үүрэг бол санхүүгийн тайлангуудад аудит хийсний үндсэн дээр өөрсдийн хөндлөнгийн дүгнэлтийг гаргах явдал юм.

Худалдаа Хөгжлийн Банкны санхүүгийн тайлангууд нь Олон Улсын Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартын дагуу бэлтгэгдсэн болно. Хөндлөнгийн хяналтын тайлангийн үндэс болсон 2001 оны 12 дугаар сарын 31-ний байдлаархи санхүүгийн тайлангуудад тухайн банкны санхүүгийн байдал болон тухайн жилийн үйл ажиллагааны үр дүнг үнэн зөв толилуулах үүргийг Төлөөлөн Удирдах Зөвлөл хүлээнэ.

Худалдаа Хөгжлийн Банкны санхүүгийн байдлыг үзүүлэх бүртгэлийн бичилт, санхүүгийн тайлангууд нь тус тайлангийн тайлбар 1 ба 2-т тусгагдсан шаардлагад нийцэж буйг Төлөөлөн Удирдах Зөвлөл батлах үүрэг хүлээнэ. Мөн Банкны активын хадгалалт, хамгаалалтанд хяналт тавьж, хөрөнгийн дутагдал, шамшигдал болон бусад хэвийн бус үйл ажиллагааг илрүүлэх болон сэргийлэх зохистой алхмуудыг авч хэрэгжүүлэх ажлыг хариуцна.

Төлөөлөн Удирдах Зөвлөл нь тус банкны санхүүгийн тайланг гаргахад үнэн зөв тооцоо, магадлал, дүн шинжилгээгээр баталгаажсан нягтлан бодох бүртгэлийн бодлого баримталсныг баталж байна. Олон Улсын Бүртгэлийн Стандартын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайлангууд нь тус тайлангийн тайлбарын үндэс болсон.

Дүгнэлтийн үндэс

Бид хөндлөнгийн хяналтыг нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн аудитын стандартад нийцүүлэн гүйцэтгэсэн болно. Аудит нь санхүүгийн тайланд тусгасан тоо хэмжээ, мэдээллийн нотолгоог тестийн үндсэн дээр шалгаж дүгнэхэд оршино. Түүнчлэн санхүүгийн тайлан бэлтгэх явцад Худалдаа Хөгжлийн Банкны удирдлагаас хийсэн чухал тооцоо, дүгнэлт болон банкны нөхцөл байдалд нийцсэн бүртгэлийн зарчмыг тууштай баримталж, зүй ёсоор мэдээлсэн эсэхэд үнэлэлт өгөхөд оршино.

Санхүүгийн тайлангууд нь хөрөнгийн дутагдал шамшигдал, бусад алдаа ба хэвийн бус ажиллагаанаас үүдэлтэй аливаа томоохон алдаа зөрүүнээс ангид болохыг нотлоход хангалттай баталгаа олж авахын тулд шаардлагатай гэж үзсэн бүхий л мэдээлэл, тайлбарыг судлах замаар бид аудитыг төлөвлөж гүйцэтгэлээ. Бид дүгнэлтээ бүрдүүлэхдээ тайлбар 1 ба 2-т үндэслэгдсэн санхүүгийн тайлангийн мэдээллийг ерөнхийд нь зохих хэмжээнд толилуулсан эсэхэд үнэлэлт өгсөн болно.

Дүгнэлт

Бидний дүгнэлтээр, санхүүгийн тайлангууд нь (хуудас 42-66) Худалдаа Хөгжлийн Банкны 2001 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Олон Улсын Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартын дагуу үнэн зөвөөр илэрхийлсэн байна.



2002 оны 2 дугаар сарын 19

Улаанбаатар

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК
 2001 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон жилийн
ОРЛОГО, ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

	Тайлбар	2001 мян.төг.	2000 мян.төг.
Хүү болон түүнтэй адилтгах орлого	3	10,701,397	10,060,103
Хүүгийн зардал болон түүнтэй адилтгах зардлууд	4	(2,609,070)	(1,527,351)
Цэвэр хүүгийн орлого		8,092,327	8,532,752
Хураамж ба шимтгэл	5	2,220,251	2,291,840
Валютын арилжаа, ханшийн тэгшитгэлийн орлого (цэвэр)	6	1,094,483	807,277
Үйл ажиллагааны бусад орлого	7	2,399,391	2,942,680
Хүүгийн бус орлого		5,714,125	6,041,797
Үйл ажиллагааны ашиг		13,806,452	14,574,549
Үйл ажиллагааны зардал	8	(4,056,684)	(3,338,571)
Эрсдлийн сан байгуулахаас өмнөх ашиг		9,749,768	11,235,978
Эрсдлийн сан	9	(491,602)	(64,569)
Татварын өмнөх ашиг		9,258,166	11,171,409
Татвар	10	(4,359,394)	(4,573,948)
Татварын дараах ашиг		4,898,772	6,597,461
Хуримтлагдсан ашиг (эхний үлдэгдэл)		9,091,978	5,420,846
Хуваарилах боломжит ашиг		13,990,750	12,018,307
Ногдол ашиг	11	(7,850,600)	(2,581,079)
Нийгмийн хөгжлийн санд хуваарилсан		(458,862)	(345,250)
Хуримтлагдсан ашиг (эцсийн үлдэгдэл)		5,681,288	9,091,978

Хавсралт тайлбар нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК
2001 оны 12 дугаар сарын 31-ний байдлаархи
ҮЛДЭГДЛИЙН ТЭНЦЭЛ

	Тайлбар	2001 мян.төг.	2000 мян.төг.
Актив			
Бэлэн мөнгө, богино хугацаат нөөц	12	7,911,306	13,074,746
Санхүүгийн бусад байгууллага дахь харилцах, хадгаламж	13	35,078,078	38,921,400
Үнэт цаасанд оруулсан хөрөнгө оруулалт	14	26,761,404	16,390,466
Зээл ба урьдчилгаа	15	33,347,800	21,005,164
Засгийн газрын төлбөрийн бичиг	16	395,594	866,749
Бусад актив	17	793,539	379,974
Татварын авлага		43,536	-
Үл хөдлөх хөрөнгө, техник тоног төхөөрөмж	18	7,450,861	6,771,411
Нийт актив		111,782,118	97,409,910
Пассив ба өөрийн хөрөнгө			
Харилцагчдын харилцах, хадгаламж	19	94,164,393	77,980,552
Санхүүгийн бусад байгууллагуудын харилцах, хадгаламж	20	2,632,157	1,501,424
Гадаадын банкнаас авсан зээл	21	3,659,213	3,549,352
Ногдол ашгийн өглөг		410,880	-
Бусад пассив	22	81,568	69,267
Татварын өглөг		-	564,718
Нийт пассив		100,948,211	83,665,313
Өөрийн хөрөнгө			
Дүрмийн сан	23	2,000,000	1,500,000
Нөөцийн сан	24	3,152,619	3,152,619
Хуримтлагдсан ашиг	25	5,681,288	9,091,978
Нийт өөрийн хөрөнгө		10,833,907	13,744,597
Нийт пассив ба өөрийн хөрөнгө		111,782,118	97,409,910
Үүрэг ба болзошгүй өр төлбөр болон тэнцлийн гадуурх зүйлс	28	80,677,920	17,574,677

Хавсралт тайлбар нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК
 2001 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон жилийн
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

	2001	2000
	МЯН.ТӨГ.	МЯН.ТӨГ.
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Татварын өмнөх ашиг	9,258,166	11,171,409
<i>Тохиргоо бичилт:</i>		
Үл хөдлөх хөрөнгө, техник тоног төхөөрөмжийн элэгдэл	399,066	352,431
Хасагдсан үл хөдлөх хөрөнгө, техник тоног төхөөрөмж	345,796	180,201
Эрсдлийн сан	444,830	64,569
Зээл төлөгдөхөд учирч болзошгүй эрсдлийн сангаас буцаасан	(1,788,227)	(2,217,313)
Үл хөдлөх хөрөнгө, техник тоног төхөөрөмж хассаны алдагдал (ашиг)	-	(642)
Ажлын капиталын өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагааны ашиг	8,659,631	9,550,655
<i>Үйл ажиллагааны активын (өсөлт) бууралт:</i>		
Зээл ба урьдчилгаа	(10,978,967)	(5,442,820)
Бусад актив	(418,821)	48,060
<i>Үйл ажиллагааны пассивын өсөлт (бууралт)</i>		
Харилцагчдын харилцах, хадгаламж	16,183,841	12,110,058
Санхүүгийн бусад байгууллагуудын харилцах, хадгаламж	1,130,733	893,764
Бусад пассив	12,301	(11,533)
Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	14,588,718	17,148,184
Орлогын татварын төлөлт	(4,967,648)	(4,842,952)
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	9,621,070	12,305,232
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Үнэт цаасанд оруулсан хөрөнгө оруулалтын цэвэр (өсөлт) бууралт	(10,381,958)	1,364,037
ЗГ-ын урт хугацаат үнэт цаасны төлөлт	467,159	491,241
Хорогдсон үл хөдлөх хөрөнгө, техник тоног төхөөрөмж	-	38,484
Худалдан авсан үл хөдлөх хөрөнгө, техник тоног төхөөрөмж	(1,424,312)	(826,470)
Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ	(11,339,111)	1,067,292
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Гадаадын санхүүгийн байгууллагаас авсан урт хугацаат зээлийн өсөлт (бууралт)	109,861	352,720
Дүрмийн сангийн өсөлт	500,000	-
Нийгмийн хөгжлийн санд оруулсан хөрөнгө	(458,862)	(345,250)
Төлсөн ногдол ашиг	(7,439,720)	(3,215,795)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(7,288,721)	(3,208,325)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн өсөлт (бууралт)	(9,006,762)	10,164,199
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	51,996,146	41,831,947
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл (тайлбар 27)	42,989,384	51,996,146

Хавсралт тайлбар нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

**ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЙЛБАР**

2001 оны 12-р сарын 31

1. САНХҮҮГИЙН ТАЙЛАН БЭЛТГЭХ ҮНДЭСЛЭЛ

Тус санхүүгийн тайлан нь Банкны үйл ажиллагаа болон түүний ашиг алдагдал, мөнгөн хөрөнгийн урсгал болон тайлан тэнцлийн хэлбэр агуулга Олон улсын бүртгэлийн стандартад нийцэж байгаа эсэхийг үнэн бодитойгоор үзүүлэх зорилгоор бэлтгэгдсэн болно. Эдгээр санхүүгийн тайлангууд нь “Арилжааны банкуудын мөрдөх санхүүгийн тайлан гаргах журам” (тус улсын төв банк болох Монголбанкнаас гаргасан) ба нягтлан бодох бүртгэлийн нэгдсэн зарчмуудын дагуу бэлтгэгдсэн болно.

Санхүүгийн тайлангуудыг нягтлан бодох бүртгэлийн өртгийн аргад үндэслэн гаргасан бөгөөд зарим активыг дахин үнэлэх замаар өөрчлөн сайжруулсан. Санхүүгийн тайланд хэрэглэгдэж буй валют нь монгол төгрөг бөгөөд мянган төгрөгөөр илэрхийлж байна.

Худалдаа Хөгжлийн Банк нь зөвхөн Монгол улсад үйл ажиллагаагаа явуулдаг нэг төрлийн бизнесийн үйл ажиллагаатай, гадаадад салбаргүй банк юм. Иймд санхүүгийн тайланд бизнесийн болон газар зүйн сегментийн хувьд ямар нэг дүн шинжилгээ хийгдээгүй болно.

2. БҮРТГЭЛИЙН БОДЛОГЫН ХУРААНГУЙ**(а) Хүүгийн орлого, зарлага**

Хүүгийн орлого, зарлагын тооцоог хуримтлуулж тооцох үндсэн дээр бүртгэсэн.

Үндсэн өр болон хүүгийн төлбөрийг эргүүлэн авах нь эргэлзээтэй тохиолдолд хүүгийн орлого тооцохыг зогсоодог. Монгол банкны журмын дагуу хүүгийн болон үндсэн өрийн төлбөр 3 сараас дээш хугацаагаар хэтэрвэл хүүг орлогод тооцохгүй. Хүүг үргэлжлүүлэн тооцохыг зогсоохдоо урьд нь хуримтлуулан тооцсон байсан хүүг орлогоос хасна. Зогсоосон хүүгийн орлогыг цаашид мөнгөн хэлбэрээр тооцно. Зээл эргэн төлөгдөх магадлалтай болсон үед хүүг хуримтлуулан тооцохыг эргэн сэргээх боломжтой.

(б) Хураамж ба шимтгэлийн орлого

Үргэлжилж буй үйлчилгээний зардал болон харилцагчийн эрсдэлээр бий болсон зардлыг нөхөх зорилгоор авсан хураамж, мөн хүүгийн орлогоос бусад авлагын үед хураамж, шимтгэлийн орлогыг бүртгэнэ.

Энэ тохиолдолд холбогдох хугацааны туршид бүртгэлийн аль зохимжтой хэлбэрийг үндэслэн хураамж, шимтгэлийг тооцно.

2. БҮРТГЭЛИЙН БОДЛОГЫН ХУРААНГУЙ (Үргэлжлэл)

(в) Гадаад валют

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн актив, пассивыг тайлан тэнцэл дэх өдрийн ханшаар хөрвүүлж төгрөгөөр илэрхийлдэг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус актив, пассивыг өртгөөр нь буюу дахин үнэлэгдсэн байдлаар илэрхийлж, гүйлгээ болон ханшийн тэгшитгэл хийсэн өдрийн ханшаар хөрвүүлж тооцно. Орлого, зарлагыг гүйлгээ хийсэн өдрийн ханшаар хөрвүүлдэг.

Мөнгөн актив, пассивын болон гадаад валютын гүйлгээний ашиг, алдагдал нь орлого, үр дүнгийн тайланд тусгагдана.

Валютын ханшийг үзүүлбэл:

	2001	2000
Ам.доллар /USD/	1,102.00	1,097.00
Дойч марк /DEM/	505.60	514.67
Фунт стерлинг /GBP/	1,599.50	1,615.11
Евро /EURO/	988.90	1,006.61
Японы иен /JPY/	8.50	9.74
Швейцари франк /CHF/	674.30	659.53
Франц франк /FRF/	150.80	153.46

(г) Зээл төлөгдөхөд учирч болзошгүй алдагдлаас хамгаалах сан

Эргэлзээтэй болон муу зээлийн болзошгүй алдагдлаас хамгаалах сан байгуулахдаа ерөнхий болон онцгой хүчин зүйлсийг харгалзан үзнэ. Банкны удирдлагын зүгээс тус санг байгуулахдаа зээлдэгчийн санхүүгийн байдал, зээлийн барьцаат хөрөнгийн үнэлгээ болон баталгаа, тухайн салбарын үйл ажиллагаа, тухайн үеийн эдийн засгийн байдал, мөн өмнөх туршлагаудыг харгалзан үзнэ. Санг /чанаргүй зээлээс төлөгдсөн дүнг хассан/ жилийн туршид ашиг, алдагдлын дансаар байгуулна.

Зээл төлөгдөхөд учирч болзошгүй алдагдлын санг Монголбанкны журмын дагуу байгуулдаг.

(д) Зээл ба урьдчилгааны төлөгдөх хугацаа

Зээлийн төлөгдөх хугацааг Тайлбар 15-д тусган харуулсан бөгөөд энэ нь зээлийг тайлан тэнцэлд тусгасан үеэс зээлийн гэрээний хугацаа дуусах үеийг хамарна.

Олон улсын санхүүгийн байгууллагуудаас болон Засгийн газрын санхүүжилтийн гэрээгээр олгож байгаа урт хугацаат зээлээс өөр урт хугацаат зээл Монголд байдаггүй. Гэвч Монголын нөхцөлд богино хугацаат зээл нь төлөгдөх хугацаа болмогц бодит шалтгаанаар дахин шинэчлэгдэх тохиолдол байдаг. Тиймээс зээлийн багцын бодит хугацаа нь гэрээнд заасан нөхцлөөр ангилсан хугацаанаас урт байх тохиолдол гарч болох юм.

2. БҮРТГЭЛИЙН БОДЛОГЫН ХУРААНГУЙ (Үргэлжлэл)

(е) Үл хөдлөх хөрөнгө, техник тоног төхөөрөмж

Банкны үл хөдлөх хөрөнгө, техник тоног төхөөрөмжийг өртгөөр буюу дахин үнэлгээний дүнгээс хуримтлагдсан элэгдлийг хасаж тусгасан болно. Үндсэн хөрөнгийн ашиглагдахаар тооцоолсон хугацаан дахь активыг балансаас хасч, шулуун шугамын аргаар элэгдлийг бодсон.

Банкны үндсэн хөрөнгийг ашиглахаар тооцоолсон хугацаа:

Барилга байшин	40 жил
Офисын тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл	10 жил
Компьютер	5 жил

Дуусаагүй барилгад элэгдэл байгуулаагүй. Эдгээр активын элэгдлийг ашиглалтанд орох үеэс нь эхлэн тооцох болно.

(ё) Түрээсээр эзэмшиж буй актив

Түрээсээр эзэмшиж буй актив нь активын өмчлөлийн эрсдэл болон үр өгөөжийг банкинд шилжүүлж байвал үндсэн хөрөнгөнд бүртгэгдэнэ. Ийм активууд болон түүнтэй холбогдох түрээсийн үүргийг түрээсийн төлбөрийн доод хэмжээний одоогийн үнэ ба түрээсээр эзэмшиж буй активын түрээсийн гэрээний эхэн үеийн бодит үнийн аль багаар бүртгэдэг. Эдгээр активд үндсэн хөрөнгийн адил элэгдэл тооцно.

Дээрх шалгуурт багтаагүй түрээсийг үйл ажиллагааны түрээс гэх ба түүний төлбөрийг ашиг, алдагдлын дансанд бүртгэнэ.

(ж) Үнэт цаасанд оруулсан хөрөнгө оруулалт

Монголбанкны үнэт цаасыг шулуун шугамын аргад үндэслэн төлөгдөх хугацаа хүртэл нь хорогдуулаагүй хямдруулалт буюу хуримтлагдсан урамшууллыг тусгасан өртгөөр үзүүлэв. Бусад төрлийн үнэт цаас жишээлбэл Засгийн газрын үнэт цаас, вексель болон компаниудын хувьцааг өртгөөр нь бүртгэдэг. Удирдлагын зүгээс энэ төрлийн хөрөнгө оруулалтын үнэ цэнэ тогтмол буурч байна гэж үзвэл Монголбанкны журмын дагуу болзошгүй алдагдлын нөөцийн сан байгуулдаг.

(з) Урьдчилсан тооцоог ашиглах

Олон улсын бүртгэлийн стандарттай нийцүүлэн санхүүгийн тайлангуудыг бэлтгэх нь удирдлагын зүгээс санхүүгийн тайлан дахь өдрийн актив, пассивын дүн болон урьдчилж тооцоогүй актив, пассивын хавсралтууд, мөн тайлагнаж буй хугацааны туршид орлого, зарлагын тайлагнаж буй дүнд нөлөөлөхүйц урьдчилсан таамаглал, тооцоо хийхийг шаарддаг. Жинхэнэ дүн нь урьдчилсан тооцооноос зөрөх магадлалтай.

3. ХҮҮ БОЛОН ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ОРЛОГО

	2001	2000
	мян.төг.	мян.төг.
Зээл ба урьдчилгаа	6,601,887	4,980,076
Гадаадын санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	1,440,733	2,234,208
Засгийн газрын бонд	1,283,064	1,991,137
Засгийн газрын өрийн бичиг	633,853	616,184
Бусад	741,860	238,498
	<u>10,701,397</u>	<u>10,060,103</u>

4. ХҮҮГИЙН ЗАРДАЛ БОЛОН ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ШИМТГЭЛҮҮД

	2001	2000
	мян.төг.	мян.төг.
Харилцах данс	667,754	512,430
Хугацаатай хадгаламж	1,231,222	962,917
Бусад	710,094	52,004
	<u>2,609,070</u>	<u>1,527,351</u>

5. ХУРААМЖ БА ШИМТГЭЛ

	2001	2000
	мян.төг.	мян.төг.
Бэлэн мөнгөний шимтгэл	897,950	970,838
Банкны чек	535,399	611,150
Кредит карт	124,037	109,833
Бусад	662,865	600,019
	<u>2,220,251</u>	<u>2,291,840</u>

Бусад хэсэгт банкнаас гаргасан чек болон шилжүүлгийн шимтгэлийн орлого хамрагдана.

6. ГАДААД ВАЛЮТЫН БОЛОН ХАНШИЙН ТЭГШИТГЭЛИЙН АШИГ
(цэвэр алдагдлыг хасаж тооцсон)

	2001	2000
	МЯН.ТӨГ.	МЯН.ТӨГ.
Гадаад валютын арилжааны цэвэр ашиг	1,003,260	765,226
Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн цэвэр ашиг	91,223	42,051
	<u>1,094,483</u>	<u>807,277</u>

7. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУСАД ОРЛОГО

	2001	2000
	МЯН.ТӨГ.	МЯН.ТӨГ.
Арилжааны орлого	130,069	53,486
Түрээсийн орлого	116,745	136,055
Данснаас урьд нь хассан зээлийн буцаалт	2,063,944	2,469,522
Бусад орлого	88,633	283,617
	<u>2,399,391</u>	<u>2,942,680</u>

8. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ

	2001	2000
	МЯН.ТӨГ.	МЯН.ТӨГ.
Цалин, ажилтнуудад олгосон нөхөн олговор, нэмэгдэл	1,736,771	1,168,081
Үндсэн хөрөнгийн элэгдэл	427,033	365,195
Үл хөдлөх хөрөнгө, техник тоног төхөөрөмж хассаны алдагдал	46,978	180,201
Албан томилолт	79,394	85,793
Орон байрны түрээс	56,320	37,954
Зочин төлөөлөгч	66,565	65,943
Зар сурталчилгаа	71,666	84,471
Судалгааны зардал (Тайлбар 21)	-	185,779
Орон сууцны хасалт	298,818	-
Бусад үйл ажиллагааны зардал	1,273,139	1,165,154
	<u>4,056,684</u>	<u>3,338,571</u>

8. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ (Үргэлжлэл)

Тухайн жилийн банкны ажиллагсдын дундаж тоог дараах байдлаар үзүүлж байна.

	2001 Тоо	2000 Тоо
Захирлууд болон газрын захирлууд	26	29
Ажилтнууд	304	259
Бусад	33	35
	363	323
Үүнээс:		
Төв	239	211
Салбарууд	124	112
	363	323

9. ЭРСДЛИЙН САНГУУД

	2001 мян.төг.	2000 мян.төг.
Зээл төлөгдөхөд учирч болзошгүй эрсдлийн сан	424,558	-
Өмчилж буй орон сууцны сан	5,256	14,571
Бусад авлагын сан	-	46,318
Хөрөнгө оруулалтын өртгийн бууралтын сан	15,016	3,680
Болзошгүй баталгааны сан	46,772	-
	491,602	64,569

10. ТАТВАР

	2001 мян.төг.	2000 мян.төг.
Тайлант оны орлогын татвар	3,937,682	4,573,948
Урьд оны татварын илүүдэл	421,712	-
	4,359,394	4,573,948

Монгол улсын татварын хуулийн дагуу банк нь орлогын татварыг тооцохдоо санхүүгийн тайланд туссан орлогоос татвар ногдохгүй орлогыг хасаж гаргадаг. Монгол улсын татварын хуулиар 100 сая төгрөгөөс доош ашгийн дүнд 15%-ийн, харин 100 сая төгрөгөөс дээш ашгийн дүнд 40%-ийн татвар тус тус ногдуулдаг байна.

11. НОГДОЛ АШИГ

	2001	2000
	мян.төг.	мян.төг.
Төлсөн:		
2000 оны эцсээрх ногдол ашиг	6,138,600	2,581,079
2001 онд урьдчилж төлсөн ногдол ашиг	1,712,000	-
	<u>7,850,600</u>	<u>2,581,079</u>

Монгол улсын Засгийн газраас гаргасан тогтоолын дагуу Банкнаас Засгийн газарт хуваарилах ногдол ашгийн зарим хэсгийг татварын албанд урьдчилан төлдөг. Үүний хэмжээг Банкны татварын дараах орлогоос тодорхой хувь тооцох байдлаар тогтоодог. Банк ногдол ашгийн энэхүү хэсгийг татварын албанд төлөх үүрэгтэй.

Тайлант онд банк 1,301 сая төгрөгийг Засгийн газарт ногдох ногдол ашгийн хэсэг байдлаар татварын албанд урьдчилж төлсөн.

12. БЭЛЭН МӨНГӨ, БОГИНО ХУГАЦААТ НӨӨЦ

	2001	2000
	мян.төг.	мян.төг.
Монголбанкин дахь харилцах данс	2,400,845	8,479,774
Бэлэн мөнгө ба бусад банкин дахь харилцах данс	5,510,461	4,594,972
	<u>7,911,306</u>	<u>13,074,746</u>

Монголбанкны шаардлагыг хангах үүднээс Монголбанкинд харилцах данс байршуулдаг бөгөөд түүнд жилийн 2.21%-иас 3.12%-ийн хүү төлөгддөг.

13. БУСАД САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУД ДАХЬ ХАДГАЛАМЖ, ХАРИЛЦАХ ДАНС

	2001	2000
	мян.төг.	мян.төг.
Гадаадын санхүүгийн байгууллагууд	<u>35,078,078</u>	<u>38,921,400</u>

Энэ нь гадаадын санхүүгийн байгууллагууд дахь гадаад валютын харилцах дансны үлдэгдэл юм. Гадаадын санхүүгийн байгууллагууд дахь харилцах дансны үлдэгдэл нь ихэнхдээ ам. доллараар илэрхийлэгддэг бөгөөд жилийн 0.25%-иас 6.08%-ийн хүүтэй байдаг. (2000 онд 1.8%-иас 6.1%-ийн хүүтэй байсан.)

14. ҮНЭТ ЦААСАНД ОРУУЛСАН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

	2001	2000
	мян.төг.	мян.төг.
Монголбанкны үнэт цаас	21,814,987	12,823,000
Засгийн газрын үнэт цаас	3,498,252	3,540,388
Хувьцаа	111,941	111,941
Вексель	1,233,480	-
Корпорацийн бонд	150,000	-
	<u>26,808,660</u>	<u>16,475,329</u>
Хорогдуулаагүй хямдруулалт	48,627	-
Хөрөнгө оруулалтын үнэт цаасны үнэлгээний бууралтанд зориулсан сан	(95,883)	(84,863)
	<u>26,761,404</u>	<u>16,390,466</u>

Монголбанкны үнэт цаас нь богино буюу нэг сараас богино хугацаатай байдаг бөгөөд төлөгдөх хугацаа хүртэл нэрлэсэн үнээсээ хөнгөлөлттэй үнээр гардаг. Засгийн газрын үнэт цаасыг Сангийн яам 1-3 сарын хугацаатай гаргадаг бөгөөд хүү нь жилийн 6.8-15.7 хувь байдаг. (2000 онд 10-17 хувь байсан.) Векселийг дотоодын компаниуд 1-3 сарын хугацаатай гаргадаг. Дээрх үнэт цаасны үлдэгдэлд хуримтлуулж тооцсон хүүний дүн нийт 77.7 сая төгрөг байна. (2000 онд 26.8 сая төгрөг байв)

Хувьцаа нь Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй компанид оруулсан хөрөнгө оруулалт юм. Банк нь тухайн компанийн хугацаа хэтэрсэн зээлийг төлүүлэх зорилгоор компанийн 11 хувийн хувьцааг худалдаж авсан. 2001 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар хувьцааны зах зээлийн үнийн дүн 26 сая төгрөг болсон ба энэ хөрөнгө оруулалтын үнэлгээний бууралтын эсрэг 96 сая төгрөгийн эрсдлийн сан байгуулсан.

15. ЗЭЭЛ, УРЬДЧИЛГАА

	2001 МЯН.ТӨГ.	2000 МЯН.ТӨГ.
Богино хугацаат зээл	35,779,094	24,849,719
Хугацаат зээл	2,247,924	2,796,378
Өөрийн ажилтнуудад олгосон зээл	35,131	18,365
Хувь нийлүүлэгчид ба холбогдох этгээдэд олгосон зээл	29,320	10,348
Нийт зээл болон урьдчилгаа	38,091,469	27,674,810
Зээл төлөгдөхөд учирч болзошгүй эрсдлийн сан		
- тусгай сан	(4,364,323)	(6,416,175)
- ерөнхий сан	(379,346)	(253,471)
	(4,743,669)	(6,669,646)
Цэвэр зээл болон урьдчилгаа	33,347,800	21,005,164
Зээлийн төлөгдөх хугацаа		
1 жилийн дотор төлөгдөх	31,491,566	24,156,064
1-5-н жилд төлөгдөх	3,876,979	722,368
5-аас дээш жилд төлөгдөх	2,722,924	2,796,378
	38,091,469	27,674,810

Зээл болон урьдчилгааг салбараар ангилан үзүүлбэл:

	2001 МЯН.ТӨГ.	2000 МЯН.ТӨГ.
Ноос, ноолуур	6,946,295	5,118,504
Уул уурхай	9,448,662	6,040,725
Худалдаа	3,306,432	1,399,572
Нефть импортлох	4,916,052	4,107,922
Хүнсний үйлдвэрлэл	7,823,500	3,033,100
Бусад	5,650,528	7,974,987
	38,091,469	27,674,810

Бусад гэдэгт эрчим хүч, барилга, үл хөдлөх хөрөнгийн салбарууд орно.

15. ЗЭЭЛ, УРЬДЧИЛГАА (Үргэлжлэл)
Чанаргүй зээлийг ангилан үзүүлбэл:

	2001	2000
	мян.төг.	мян.төг.
Нийт чанаргүй зээл (12-р сарын 31-ний байдлаар)	5,664,416	6,468,674
нийт зээл болон урьдчилгаанд эзлэх хувь	15 %	23%
Чанаргүй зээл (цэвэр)	1,300,093	52,499
нийт цэвэр зээлд эзлэх хувь	3.9 %	0.3%

Эргэлзээтэй ба муу зээлд байгуулсан сангийн өөрчлөлтийг үзүүлбэл:

	2001	2000
	мян.төг.	мян.төг.
Тусгай сан		
1-р сарын 1-ний үлдэгдэл	6,416,175	8,620,659
Зардлаар байгуулсан	391,564	-
Ерөнхий санд шилжсэн	(80,734)	-
Сангаас буцаасан	(1,788,227)	(2,212,991)
Сангаас хассан	(574,455)	(24,827)
Ханшийн зөрүү	-	33,334
12-р сарын 31-ний үлдэгдэл	<u>4,364,323</u>	<u>6,416,175</u>
Ерөнхий сан		
1-р сарын 1-ний үлдэгдэл	253,471	180,967
Зардлаар байгуулсан	32,994	-
Тусгай сангаас шилжиж ирсэн	80,734	-
Сангаас буцаасан	-	(4,322)
Ханшийн зөрүү	12,147	76,826
12-р сарын 31-ний үлдэгдэл	<u>379,346</u>	<u>253,471</u>

Зээл болон урьдчилгаанд нийт **875 сая төгрөгийн** хүү хуримтлуулсан.

15. ЗЭЭЛ, УРЬДЧИЛГАА (Үргэлжлэл)

Банкны нийт зээлийн өрийн үлдэгдэл 2001 оны 12-р сарын 31-ний байдлаар 38.1 тэрбум төгрөг байсны 5.7 тэрбум төгрөг нь чанаргүй гэсэн ангилалд байна.

Нийт 4.7 тэрбум төгрөгийн тусгай болон ерөнхий санг чанаргүй зээлийн эсрэг байгуулсан бөгөөд сангийн хэмжээ нь нийт чанаргүй зээлийн 77%-ийг хааж байгаа юм.

Банкны өнөөгийн мөрдөж байгаа аргачлалаар тусгай сангийн хэмжээг чанаргүй зээлдэгч тус бүрийн нөхцөл байдалд үнэлгээ хийсний үндсэн дээр, харин ерөнхий сангийн хэмжээг банкны нийт зээлийн багцад үнэлгээ хийсний үндсэн дээр тогтоодог байна. Тиймээс эдгээр сан нь тухайн цаг үеийн нөхцөл байдал, тухайн үед байсан мэдээлэл дээр үндэслэдэг байна. Зээлийн болзошгүй алдагдлын санг байгуулахдаа банкны активын чанарт ирээдүйд гарч болох эрсдлийг тооцдоггүй.

Зээлийн хороо эдийн засгийн ерөнхий байдал болон зээл бүр дээр дүн шинжилгээ хийсний үндсэн дээр зээлийн болзошгүй эрсдлийн санг хүрэлцээтэй гэж үзсэн.

16. ЗАСГИЙН ГАЗРЫН ТӨЛБӨРИЙН БИЧИГ

	2001	2000
	МЯН.ТӨГ.	МЯН.ТӨГ.
1-р сарын 1-ний байдлаар	866,749	1,317,419
Буцаасан төлбөр	(467,159)	(450,670)
12-р сарын 31-ний байдлаар	399,590	866,749
Болзошгүй эрсдлийн сан	(3,996)	-
	<u>395,594</u>	<u>866,749</u>

Эдгээр Засгийн газрын төлбөрийн бичгийг 1997 оны 7-р сард гаргасан бөгөөд энэ нь захиргаадлын болон шилжиж ирсэн зээлийг Засгийн газрын өрийн бичгээр сольсонтой холбоотой юм. Эдгээр өрийн бичгийн хугацаа тодорхойгүй байгаа бөгөөд төлбөрийн нөхцөлийн талаар Банк болон Засгийн газар хооронд хэлэлцэж байна.

Эдгээр өрийн бичгийн хүүг улирал, хагас жилд төлөхөөр Банк Засгийн газартай тохиролцсон. Банк өрийн бичгийн хүүгийн хэмжээг хэлэлцэн тохиролцсоны үндсэн дээр тодорхой хугацаанд хүүний орлогыг хуримтлуулж тооцсон.

Засгийн газар хэдийгээр эхний хагас жилийн хүүгийн төлбөрийг төлсөн боловч дараагийн хагас жилийн хүүгийн төлбөрийг төлөхгүй гэдгээ мэдэгдсэн.

2001 онд өрийн бичгийн хүүгийн орлогод 37 сая төгрөг авсан.

17. БУСАД АКТИВ

	2001	2000
	мян.төг.	мян.төг.
Өмчлөх бус үндсэн хөрөнгө	529,381	26,072
Урьдчилж төлсөн зардал	63,625	107,547
Материал	134,867	122,253
Алт ба бусад үнэт металл	22,026	21,372
Бусад авлага	43,640	25,530
Ажилчдын орон сууц	-	77,200
	793,539	379,974

Өмчлөх бус үндсэн хөрөнгөнд 2.4 тэрбум төгрөгийн сан байгуулагдсан (2000 онд 1.9 тэрбум). Монголбанкнаас тухайн жил гаргасан журмын дагуу энэ санг байгуулсан.

18. ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ, ТЕХНИК ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

	Барилга байшин	Тавилга тээврийн хэрэгсэл	Компьютер	Дуусаагүй барилга	Нийт дүн
	мян.төг.	мян.төг.	мян.төг.	мян.төг.	мян. төг.
Бүртгэлээрх үнэ /цэвэр/					
2001 оны 1-р сарын					
1-ний байдлаар	5,308,099	868,018	368,554	226,740	6,771,411
Нэмэгдсэн	206,719	16,856	115,816	1,079,865	1,419,256
Хорогдсон	-	-	-	-	-
Шилжсэн	353,274	130,183	695,084	(1,199,444)	(20,903)
Зарлагдсан	(324,470)	(784)	(58)	(20,484)	(345,796)
Эхний үлдэгдэлд байгуулсан элэгдэл	(137,215)	(122,347)	(113,545)	-	(373,107)
2001 оны 12-сарын 31-ний байдлаар	5,406,407	891,926	1,065,851	86,677	7,450,861
2001 оны 12-сарын 31-ний байдлаар					
Өртөг	5,713,442	1,411,481	1,401,177	86,677	8,612,777
Хуримтлагдсан элэгдлийн эхний үлдэгдэл	(169,102)	(387,997)	(234,380)	-	(791,479)
Зарлагдсан болон хасагдсан хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл	570	2,833	25,226	-	28,629
Жилд байгуулсан хуримтлагдсан элэгдэл	(138,503)	(134,391)	(126,172)	-	(399,066)
	5,406,407	891,926	1,065,851	86,677	7,450,861
2000 оны 12-р сарын 31-ний байдлаар					
Өртөг	5,477,201	1,256,015	602,934	226,740	7,562,890
Хуримтлагдсан элэгдлийн эхний үлдэгдэл	(22,317)	(286,457)	(132,931)	-	(441,705)
Зарлагдсан болон хасагдсан хуримтлагдсан элэгдэл	-	16,018	1,674	-	17,692
Жилд байгуулсан хуримтлагдсан элэгдэл	(135,159)	(117,593)	(99,679)	-	(352,431)
Тохиргоо	(11,626)	35	(3,444)	-	(15,035)
	5,308,099	868,018	368,554	226,740	6,771,411

19. ХАРИЛЦАГЧИЙН ХАРИЛЦАХ, ХАДГАЛАМЖ

	2001	2000
	мян.төг.	мян.төг.
Харилцах данс	66,216,379	55,442,890
Хугацаагүй хадгаламж	10,615,333	9,613,218
Хугацаатай хадгаламж	13,732,869	11,776,106
Бусад харилцах, хадгаламж	3,599,812	1,148,338
	<u>94,164,393</u>	<u>77,980,552</u>

Харилцах дансанд ерөнхийдөө хүү төлдөггүй, гэхдээ харилцах дансандаа үлдэгдэлтэй байх тодорхой шаардлагыг хангасан нөхцөлд валютын харилцах дансанд жилийн 1 хувийн, төгрөгийн харилцах дансанд жилийн 3 хувийн хүү төлдөг. (2000 онд 1 хувь, 3 хувь байв.)

Гадаад валютын хугацаагүй хадгаламжийн хүү жилийн 1.8 хувь (2000 онд 1.8 хувь байв), төгрөгийн хугацаагүй хадгаламжийн хүү жилийн 6 хувь байдаг. (2000 онд 9.6 хувь байв.)

Хугацаатай хадгаламжийн хүү нь дансны төрлөөсөө хамааран ялгавартай байдаг. Валютын хугацаатай хадгаламжийн хүү жилийн 3.6-5.4 хувь (2000 онд 3.6-5.4 хувь байв.), төгрөгийн хугацаатай хадгаламжийн хүү жилийн 13.2 хувиас 14.4 хувь байдаг. (2000 онд 13.2 , 21.6 хувь тус тус байв.)

20. БУСАД САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН БАЙРШУУЛСАН ХАРИЛЦАХ, ХАДГАЛАМЖ

	2001	2000
	мян.төг.	мян.төг.
Гадаад валютын харилцах данс	2,611,486	1,469,564
Худалдах гадаад валютын чек	20,671	31,860
	<u>2,632,157</u>	<u>1,501,424</u>

Дотоодын арилжааны банкууд гадаад валютын харилцах дансаа тус банкинд байршуулдаг ба энэ дансанд ерөнхийдөө хүү төлдөггүй. Гэхдээ харилцах дансны үлдэгдлийн тодорхой шаардлагыг хангасан нөхцөлд жилийн 1 хувийн хүү төлдөг.

21. ГАДААДЫН САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДААС АВСАН ЗЭЭЛ

	2001	2000
	МЯН.ТӨГ.	МЯН.ТӨГ.
Олон улсын байгууллагуудаас авсан зээл	3,659,213	3,549,352

Энэ нь Монголбанк болон Сангийн ямаар дамжуулан Германы Засгийн Газрын банк болох Kreditanstalt fuer Wiederaufbau (цаашид KfW гэх), Дэлхийн банк (цаашид ДБ гэх)-ны Олон Улсын Хөгжлийн Ассоциац (цаашид ОУХА гэх)-аас хувийн секторын хөгжлийг дэмжих зорилгоор авсан зээл юм.

2001 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар KfW-д төлөх зээлийн өрийн үлдэгдэл 4.7 сая Deutsche Mark (DEM) буюу 2.4 тэрбум төгрөг (2000 онд 4.7 сая DEM буюу ойролцоогоор 2.4 тэрбум төгрөг), ОУХА-д төлөх зээлийн өрийн үлдэгдэл 581 мянган ам. доллар буюу 640 сая төгрөг (2000 онд 581 мянган ам. доллар буюу ойролцоогоор 637 сая төгрөг), Дэлхийн банкинд төлөх зээлийн өрийн үлдэгдэл 582 мянган ам. доллар буюу ойролцоогоор 641 сая төгрөг (2000 онд 448 мянган ам. доллар буюу ойролцоогоор 492 сая төгрөг) байна.

KfW-гийн зээлийг хөнгөлөлттэй хүүтэйгээр төрөл бүрийн харилцагчдын бизнесийг санхүүжүүлэхэд ашигладаг. 2001 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар эдгээр харилцагчдад олгосон зээлийн өрийн үлдэгдэл нь 4.5 сая DEM байна (2.3 тэрбум төгрөг).

Тус банк KfW-ийн зээлд жилийн 1.75%-ийн хүү төлөхөөр тогтоогдсон бөгөөд үүний 0.75%-ийг KfW-д, үлдэх 1%-ийг Монголбанкинд төлдөг байна. Энэхүү зээлийн үндсэн өр 2001 оны 12-р сараас эхлэн төлөгдөж 2007 оны 12-р сард зээлийн эцсийн төлбөр хийгдэж дуусах ёстой.

ОУХА-аас авсан зээл нь Norwegian Banking Resources Ltd (цаашид NBR гэх)-тай байгуулсан Хамтын ажиллагааны Гэрээг санхүүжүүлэхэд зориулагдсан юм. Энэхүү Гэрээ ёсоор NBR нь тус банкны үр ашигтай үйл ажиллагаа, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, удирдлагын болон санхүү, техникийн үр чадварыг сайжруулахад туслах юм.

2001 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар энэхүү Хамтын ажиллагааны хөтөлбөр нь амжилттай болж өнгөрсөн ба хөтөлбөрийн нийт зардал 581 мянган ам. доллар буюу ойролцоогоор 570 сая төгрөгт хүрсэн ба үүнээс судалгааны зардалд 1998 онд 241 сая төгрөг, 1999 онд 145 сая төгрөг тус тус зарцуулсан байна. Энэ зардлын үлдэгдэл болох 186 сая төгрөгийг 2000 онд зарцуулсан байна. Энэхүү зээлийн төлбөр нь 2007 оны 8-р сараас төлөгдөж эхлэх ба зээлийн эцсийн төлбөр 2037 оны 2-р сард дуусна.

Дэлхийн банкны зээл нь Хувийн Секторийн Хөгжлийг Дэмжих Хөтөлбөрийн хүрээнд харилцагчдын бизнесийг дэмжихэд зориулагдсан. Энэхүү зээлийн хүү нь хувьсах бөгөөд 6 сарын LIBOR-ын хүүн дээр тухайн арилжааны банкны жилд хүлээж болох эрсдэл 3%-ийг нэмсэнтэй тэнцүү байна. Хүүгийн хэмжээг 3 сар тутам шинээр буюу 3, 6, 9, 12-р саруудын эхний өдрийн LIBOR-ын хүүнд үндэслэн тогтоох бөгөөд үүний хэмжээг Санхүү-Эдийн засгийн яамны ажлын хэсгийн мэргэжилтнүүд болон энэхүү зээлийн хөтөлбөрт оролцож байгаа арилжааны банкууд хамтран тодорхойлно.

22. БУСАД ПАССИВ

	2001 мян.төг.	2000 мян.төг.
Гадаад гуйвуулга	11,801	16,915
Клирингийн хойшлогдсон төлбөр	992	383
Бусад өглөг	68,775	51,969
	81,568	69,267

23. ДҮРМИЙН САН

	2001 мян.төг.	2000 мян.төг.
1-р сарын 1-ний үлдэгдэл	1,500,000	1,500,000
Тайлант онд нэмэгдсэн	500,000	-
	2,000,000	1,500,000

2001 оны 12-р сарын 31-нээр үйлчилж буй банкны хуулиар бүх арилжааны банкны дүрмийн сангийн доод хэмжээ 2 тэрбум төгрөг байхаар заажээ.

Санхүүгийн тайлангийн жилд банк дүрмийн сангаа нэг бүр нь 1000 төгрөгний нэрлэсэн үнэтэй 500 мянган ширхэг, 500 сая төгрөгийн энгийн хувьцаа гаргаж нэмэгдүүлсэн.

Нэмж гаргасан 500,000 ширхэг энгийн хувьцааны 470,000 ширхэг нь Засгийн газарт 30,000 ширхэг нь бусад хувьцаа эзэмшигчдэд зарагдсан.

Тус банкны нийт дүрмийн сангийн 76 хувийг Монгол Улсын Засгийн Газар, үлдэх 24 хувийг тус банкны ажилтнууд эзэмшиж байна.

24. НӨӨЦИЙН САНГУУД

	2001 мян.төг.	2000 мян.төг.
1-р сарын 1-ний үлдэгдэл	3,152,619	3,217,672
Тохируулга	-	(65,053)
	3,152,619	3,152,619

25. ХУРИМТЛАГДСАН АШИГ

	2001	2000
	мян.төг	мян.төг.
1-р сарын 1-ний	9,091,978	5,420,846
Жилийн цэвэр өсөлт	4,898,772	6,597,461
Ногдол ашиг	(7,850,600)	(2,581,079)
Нийгмийн хөгжлийн санд шилжүүлсэн	(458,862)	(345,250)
12-р сарын 31-ний үлдэгдэл	5,681,288	9,091,978

26. ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ТОХИРУУЛГЫН ТАЙЛАН

	2001	2000
	мян.төг	мян.төг.
Өөрийн хөрөнгө (1-р сарын 1)	13,744,597	10,138,518
Жилийн ашиг	4,898,772	6,597,461
Тохируулга	-	(65,053)
Дүрмийн сангийн өсөлт	500,000	-
Нийгмийн хөгжлийн санд шилжүүлсэн	(458,862)	(345,250)
Ногдол ашиг	18,684,507	16,325,676
	(7,850,600)	(2,581,079)
Өөрийн хөрөнгө (12-р сарын 31)	10,833,907	13,744,597

27. БЭЛЭН МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

	2001	2000
	мян.төг.	мян.төг
Тайлан тэнцэлд бэлэн мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийг дараах зүйлүүдээр илэрхийлсэн болно. Үүнд:		
Бэлэн мөнгө, богино хугацаат нөөц	7,911,306	13,074,746
Бусад санхүүгийн байгууллагууд дахь харилцах, хадгаламж	35,078,078	38,921,400
	42,989,384	51,996,146

28. ҮҮРЭГ БА БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР

а) Санхүүгийн үүрэг ба болзошгүй өр төлбөр, тэнцлийн гадуурх зүйлс

Банк нь харилцагчдынхаа өмнө хуулийн хүрээнд үүрэг хариуцлага хүлээдэг. Үүний үр дүнд гарч болох ямар нэгэн бодит алдагдал урьдчилан тооцогдоогүй.

	2001	2000
	МЯН.ТӨГ	МЯН.ТӨГ.
Нээлттэй аккредитив	10,887,901	2,703,571
Гаргасан баталгаа	275,500	309,736
Бусад тэнцлийн гадуурх зүйлс	69,514,519	14,561,370
	<u>80,677,920</u>	<u>17,574,677</u>

2001 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар тус банкнаас гаргасан баталгаа болон нээлттэй аккредитив нь барьцаа хөрөнгөөр баталгаажсан бөгөөд үүний ихэнх нь мөнгөн хэлбэрээр барьцаалагдсан тул зээлийн эрсдэлгүй байна.

Тус банк гадаад валютын арилжааны Форвард болон Опшин гэрээ хэлцэлд оролцсон. 2001 оны 12-р сарын 31-ний байдлаар банкны Форвард болон Опшин гэрээний өртөг 81.3 тэрбум төгрөг болон 2.1 тэрбум төгрөг тус тус байсан. Эдгээр хэлцэлүүд нь 2001 оны 12-р сарын 31-ний байдлаар бүрэн хамгаалагдсан бөгөөд эдгээр хэлцэл болон тэнцлийн гадуурх зүйлс нь зах зээлийн эрсдэлд орохгүй.

Засгийн газар хоорондын зээлийн өрийн үлдэгдэл нь 2001 оны 12-р сарын 31-нээр 3.2 тэрбум төгрөг байсан бөгөөд үүнийг бусад тэнцлийн гадуурх зүйлд тусгасан. Эдгээр зээл нь Монголын Засгийн Газраас гадаадын хэд, хэдэн улсын Засгийн газарт төлөх зээл юм. Банк нь эдгээр зээлийн талаар аливаа хууль ёсны хариуцлага хүлээхгүй, зөвхөн төлбөр тооцоог нь гүйцэтгэдэг тул эдгээрийг тайлан тэнцэлд тусгаагүй байна.

2001 оны 12-р сарын 31-нээрх бусад тэнцлийн гадуурх зүйлсийг бүтцээр нь авч үзвэл 55.3 тэрбум төгрөгийн зээлийн барьцаа хөрөнгө, 6 тэрбум төгрөгийн тэнцлээс хасагдсан зээл болон 3.1 тэрбум төгрөгийн өртөгтэй замын чек байна. Үлдсэн хэсгийг нь харилцагчийн нэр дээр ирсэн хугацаандаа төлөгдөөгүй инкасс бүрдүүлж байна. Эдгээр төлбөртэй холбоотой банк ямар нэгэн хариуцлага хүлээхгүй.

б) Хөрөнгийн үүрэг

2000 болон 2001 оны 12-р сарын 31-ний байдлаар тус банкны удирдлагууд ямар нэг томоохон хөрөнгийн үүргийг батлаагүй байна.

29. ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА

Монголбанкнаас арилжааны банкуудад тогтоосон шалгуур үзүүлэлт болох өөрийн хөрөнгийн зохистой харьцаа 10% байдаг. Үүнийг нийт хөрөнгө болон нийт активыг эрсдэлээр нь жигнэсний үндсэн дээр тогтоодог. 2001 оны 12-р сарын 31-ний байдлаар банкны 1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн харьцаа 12.7%, (2000 онд 27.9%), эрсдэлээр жигнэсэн хөрөнгийн харьцаа 15.7% (2000 онд 32.3%) байна. Тус банкны хөрөнгийн зохистой харьцааг доорх хүснэгтээр харуулбал:

	2001 мян.төг.
1-р зэрэглэлийн хөрөнгө	
Дүрмийн сан	2,000,000
Ашиг, алдагдлын данс	5,681,288
Нийт 1-р зэрэглэлийн хөрөнгийн дүн	<u>7,681,288</u>
2-р зэрэглэлийн хөрөнгө	
Дахин үнэлгээний нөөц	1,418,679
Зээлийн болзошгүй алдагдлын ерөнхий сан	379,346
Нийт хөрөнгийн дүн	<u><u>9,479,313</u></u>

Эрсдэлээр нь жигнэсэн активуудыг эзлэх хувийн жингээр нь үзүүлбэл:

	2001 мян.төг.
%	
0	32,830,570
10	-
20	38,718,827
50	244,821
100	52,680,457
Нийт дүн	<u><u>124,474,675</u></u>
1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн харьцаа	12.69%
Эрсдэлээр жигнэсэн хөрөнгийн харьцаа	15.66%
1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн харьцаа –2000	27.91%
Эрсдэлээр жигнэсэн хөрөнгийн харьцаа – 2000	32.32%

30. ХОЛБОГДОХ ЭТГЭЭДТЭЙ ХИЙСЭН ГҮЙЛГЭЭ

Тус банкны 2001 онд холбогдох этгээдтэй хийсэн гүйлгээнд зөвхөн тус банкны захирлууд болон ажилчдад олгосон зээл орно.

	мян. төг
Захирлуудад олгосон зээл	29,320
Ажилчдад олгосон зээл	35,131
Холбогдох этгээдэд олгосон зээл (нийт)	64,451
Болзошгүй алдагдлын сан	(636)
2001 оны 12-р сарын 31-ээрх холбогдох этгээдэд олгосон зээл (цэвэр)	63,815

31. ГАДААД ВАЛЮТААР ИЛЭРХИЙЛЭГДСЭН АКТИВ БОЛОН ПАССИВ

	2001 оны 12 сарын 31 (мян. төг)		
	Төгрөг	Гадаад валют	Нийт
Актив			
Бэлэн мөнгө, богино хугацаат нөөц	3,887,346	4,023,960	7,911,306
Санхүүгийн бусад байгууллага дахь харилцах, хадгаламж	-	35,078,078	35,078,078
Үнэт цаасанд оруулсан хөрөнгө оруулалт	25,527,924	1,233,480	26,761,404
Зээл ба урьдчилгаа	12,373,249	20,974,551	33,347,800
Засгийн газрын үнэт цаас	395,594	-	395,594
Бусад актив	318,850	474,689	793,539
Татварын авлага	43,536	-	43,536
Үл хөдлөх хөрөнгө, техник тоног төхөөрөмж	7,450,861	-	7,450,861
Нийт актив	49,997,360	61,784,758	111,782,118
Пассив ба өөрийн хөрөнгө			
Харилцагчдын харилцах, хадгаламж	40,379,548	53,784,845	94,164,393
Санхүүгийн бусад байгууллагуудын харилцах, хадгаламж	-	2,632,157	2,632,157
Гадаадын банкнаас авсан зээлийн эх үүсвэр	-	3,659,213	3,659,213
Ногдол ашгийн өглөг	410,880	-	410,880
Бусад пассив	49,096	32,472	81,568
Татварын өглөг	-	-	-
Нийт пассив	40,839,524	60,108,687	100,948,211
Дүрмийн сан	2,000,000	-	2,000,000
Нөөцийн сан	3,152,619	-	3,152,619
Хуримтлагдсан ашиг	5,681,288	-	5,681,288
Нийт өөрийн хөрөнгө	10,833,907	-	10,833,907
Нийт пассив ба өөрийн хөрөнгө	51,673,431	60,108,687	111,782,118

32. АКТИВ БОЛОН ПАССИВ ХӨРӨНГИЙН БУЦААН ТӨЛӨГДӨХ ХУГАЦАА

(2001 оны 12 сарын 31-ний байдлаар. /Мян.төг/)

	0-3 сар	3-6 сар	6-12 сар	1-5 жил	5 дээш	Нийт
Актив						
Бэлэн мөнгө, богино хугацаат нөөц	7,911,306	-	-	-	-	7,911,306
Санхүүгийн бусад байгууллага дахь харилцах, хадгаламж	35,078,078	-	-	-	-	35,078,078
Үнэт цаасанд оруулсан хөрөнгө оруулалт	26,595,346	150,000	-	16,058	-	26,761,404
Зээл ба урьдчилгаа	5,091,242	10,462,476	14,939,009	1,745,773	1,109,300	33,347,800
Засгийн газрын үнэт цаас	-	-	395,594	-	-	395,594
Бусад актив	793,539	-	-	-	-	793,539
Татварын авлага	43,536	-	-	-	-	43,536
Үл хөдлөх хөрөнгө, техник тоног төхөөрөмж	-	-	-	-	7,450,861	7,450,861
	<u>75,513,047</u>	<u>10,612,476</u>	<u>15,334,603</u>	<u>1,761,831</u>	<u>8,560,161</u>	<u>111,782,118</u>
Пассив						
Харилцагчдын харилцах, хадгаламж	79,549,993	5,656,900	5,197,900	3,759,600	-	94,164,393
Санхүүгийн бусад байгууллагуудын харилцах, хадгаламж	2,632,157	-	-	-	-	2,632,157
Гадаадын банкнаас авсан зээлийн эх үүсвэр	104,300	56,100	93,500	1,973,600	1,431,713	3,659,213
Ногдол ашгийн өглөг	410,880	-	-	-	-	410,880
Бусад пассив	81,568	-	-	-	-	81,568
	<u>82,778,898</u>	<u>5,713,000</u>	<u>5,291,400</u>	<u>5,733,200</u>	<u>1,431,713</u>	<u>100,948,211</u>
Цэвэр зөрүү	(7,265,851)	4,899,476	10,043,203	(3,971,369)	7,128,448	10,833,907
Өсөн нэмэгдэх GAP	(7,265,851)	(2,366,375)	7,676,828	3,705,459	10,833,907	

33. ОНЫ ЯВЦАД ГАРСАН ЧУХАЛ ҮЙЛ ЯВДАЛ

2001-2004 онд төрийн өмчийг хувьчлах Улсын Их Хурлаас баталсан үндсэн чиглэлийн дагуу Монгол Улсын Засгийн Газар “2001 онд баримтлах хувьчлалын хөтөлбөр”-ийг 2001 оны 2-р сард баталсан. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсын Засгийн Газар тус банкны өөрийн мэдлийн 76 хувийг тендерээр худалдахаар болсон.

34. ХАРЬЦУУЛАГДАХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2001 оны үзүүлэлтүүдийг тайлант хугацааны үзүүлэлтүүдтэй харьцуулан харуулсан болно.

35. МОНГОЛ ХЭЛ ДЭЭРХ ОРЧУУЛГЫН ТАЛААР

Баталгаажсан санхүүгийн тайлан нь мөн монгол хэл дээр орчуулагдсан болно. Монгол болон англи хэллэгийн ялгаа болон зөрүү гарсан байвал англи хэл дээр толилуулсан санхүүгийн тайланг голчлон үзнэ үү.